



ХОС ХЭЛНИЙ БОЛОВСРОЛЫН БОДЛОГЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ (СУДАЛГААНЫ НЭГТГЭСЭН ТАЙЛАН)



UIH.MN
СУДАЛГААНЫ САН

«БҮХ НИЙТ БОЛОВСРОЛЫН ТӨЛӨӨ!»
ИРГЭНИЙ НИЙГМИЙН ҮНДЭСНИЙ ЭВСЭЛ

ХОС ХЭЛНИЙ БОЛОВСРОЛЫН БОДЛОГЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ НЭГТГЭСЭН ТАЙЛАН

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Улаанбаатар хот
2021 он

Судлаачид:

"Хос хэлний боловсролын талаарх бодлогын хэрэгжилт, зохицуулалтад хийсэн мониторинг" хийсэн Ж.Зульмира (Боловсролын хүрээлэнгийн судлаач, Боловсрол эвслийн Баян-Өлгий аймаг дахь салбар зөвлөлийн гишүүн)

"Хот суурин газар амьдарч буй казак иргэдийн эх хэлний хэрэглээг судлах онлайн судалгаа"-г хийсэн Б.Алтангүл (МУИС-ийн Европ судлалын тэнхимийн багш, доктор, профессор), Б.Ардак ("Бүх нийт боловсролын төлөө!" Иргэний нийгмийн үндэсний эвслийн Налайх дүүргийн салбар зөвлөлийн зохицуулагч), Г.Чулуун-Эрдэнэ (МУБИС-ийн Англи хэлний тэнхимийн багш, докторант), Б.Бахатгүл (Бие даасан судлаач)

Хос хэлний сургалтын нэг элемент болох соёлын мэдлэгт анхаарах хэрэгцээ судалгааг Д.Тунгалаг ("Бүх нийт боловсролын төлөө!" Иргэний нийгмийн үндэсний эвслийн ерөнхий зохицуулагч)

Редактор

Д.Тунгалаг ("Бүх нийт боловсролын төлөө!" Иргэний нийгмийн үндэсний эвслийн ерөнхий зохицуулагч)

Хавтасны зургийг Д.Давааням (баримтат гэрэл зурагчин)

"Боловсролын төлөө чанга дуугарцгаая!" төслийн санхүүжилтээр хэвлэв.

ӨМНӨХ ҮГ

“Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвсэл 2010 онд анх байгуулагдахдаа боловсролын тогтолцоог хүний эрхэд суурилсан байдлаар өөрчлөн шинэчлэх зорилго тавьж ирсэн. Бидний санал болгосон бодлогын шинэчлэл нь бүгдийг тэгш хамран сургах бодлого бөгөөд үүнд үндэстний цөөнх казах, тува иргэдийн эх хэлээрээ суралцах эрх мөн багтана.

“Хүний эрхийн түгээмэл тунхаглал”, “Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт”, НҮБ-ын Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны байгууллагын “Боловсрол дахь ялгаварлалын эсрэг конвенц”, “Үндэс угсаа, арьс өнгөөр ялгаварлахын эсрэг тунхаглал” зэрэг олон улсын гэрээ, конвенцид үндэстний цөөнх эх хэлээрээ боловсрол эзэмших, суралцах эрх, соёлын ялгаатай байдлыг дэмжих, хүлээн зөвшөөрөх зэрэг асуудлууд туссан байдаг. Тиймээс ч Монгол Улсын Үндсэн хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт “Монгол хэл бол төрийн албан ёсны хэл мөн” гэж, мөн зүйлийн 8.2 дахь хэсэгт “Энэ зүйлийн 1 дэх хэсгийн заалт нь хүн амын өөр хэл бүхий үндэстний цөөнх эх хэлээрээ суралцах, харилцах, соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах эрхийг үл хөндөнө” гэж зааж, Монгол хэлний болон Боловсролын тухай хуулиудын заалтаар ч баталгаажсан байдаг.

Гэвч бодит байдал дээр үндэстний цөөнхийн хүүхдүүдийн сурч боловсрох эрх зөрчигдсөөр ирсэнд Боловсрол эвсэл анхаарал хандуулан бодлогын нөлөөллийн суурь нотолгоо болох хэд хэдэн судалгаанууд хийснээ нэгтгэн танилцуулж байна.

Аливаа эрх зөрчигдөх суурь нь тогтолцоонд байдаг буюу тэдгээр бүлгийн суралцагчдын талаарх бодлого шийдвэр хийдэлтэй, төсөв хөрөнгө оруулалт дутуу дулимаг, эсвэл тэдгээр бүлгийн эрэлт хэрэгцээ онцлогийг үйл хайхрах төрийн албан хаагчдын хүний эрхийн мэдлэг, мэдрэмжийн асуудал байдгийг эдгээр судалгааны дүн харуулсан.

Бидний нэгэн судалгаанд оролцогчдын дийлэнх нь «Монгол улсад амьдарч буй үндэстний цөөнхийн төлөөллийн хувьд 1. эх орноороо; 2. эрх чөлөөгөөрөө; 3. үндэстний хэл, соёл, ёс заншлаараа бахархана» гэж хариулсан байна. Мөн «1. олон нийтийн сүлжээн дэх ялгаварлан гадуурхалт, доромжлол; 2. Таваас арван жилийн дараа үр хүүхдүүд маань үндэсний эх хэл, соёлоо алдах вий гэхээс; 3. боловсролын салбарын тулгамдаж буй асуудал шийдэгдэж, төрийн хэлний мэдлэг чадвар дээшлэхгүй байгаад санаа зовж, эмзэглэж байна» хэмээсэн нь танд нэгийг бодогдуулах байх.

Судалгааг хийхэд хамтран ажилласан бидний түнш МУИС-ийн ШУС-ийн багш, доктор, профессор Б.Алтангүл, Боловсрол эвслийн Налайх дүүргийн салбар зөвлөлийн зохицуулагч Б.Ардак, Баян-Өлгий аймгийн салбар зөвлөлийн гишүүн Ж.Зүлмира нартаа Боловсрол эвслийн нийт гишүүдийн нэрийн өмнөөс талархаж буйгаа илэрхийлье!

Ерөнхий зохицуулагч Д.Тунгалаг

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ХОС ХЭЛНИЙ БОЛОВСРОЛЫН ТАЛААРХ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ЗОХИЦУУЛАЛТАД ХИЙСЭН МОНИТОРИНГИЙН ТАЙЛАН

Монгол Улсад амьдарч буй үндэстний цөөнх болох казах, тувачуудын дийлэнх нь Баян-Өлгий аймагт амьдардаг. Үндэстний цөөнхийн хүүхдүүдийн сурлагын чанар, ялангуяа хос хэлний боловсролын талаар сүүлийн үед их яригддаг болсон. Тухайн чиглэлээр хийгдэж буй судалгааны ажил ч цөөнгүй байна.

Манай энэ удаагийн судалгааны ажлын гол зорилго нь:

Хос хэлний сургалтын талаарх судалгаа, шинжилгээг өргөжүүлэх, бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд мониторинг хийх, Монгол Улсын үндэстний цөөнхийн хос хэлний сургалтын цаашдын чиг хандлагыг судалгааны үндсэн дээр тодорхойлох, сайжруулахад хувь нэмэр оруулахад оршино.

Дэвшүүлсэн зорилгод хүрэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллав . Үүнд:

- Судалгааны арга зүйг боловсруулах;
- Судалгааны хэрэглэгдэхүүн боловсруулах (санал асуулгын хуудас, чиглүүлэх асуулт, гэх мэт);
- Мэдээлэл цуглуулах;
- Цуглуулсан мэдээллээ нэгтгэж, шинжилгээ хийх;
- Үндэстний цөөнхийн хос хэлний сургалтын цаашдын чиг хандлагыг судалгааны үндсэн дээр тодорхойлох;
- Тайлан боловсруулах

Судалгааны ажилд Баян-Өлгий аймгийн ерөнхий боловсролын 10 сургууль болон Ховд Их сургуулийн Баян-Өлгий аймаг дахь салбар сургуулийн оюутан, сурагч, багш, удирдлага, эцэг эхийн төлөөллийн хамт аймгийн Нийгмийн бодлогын хэлтсийн дарга, Боловсрол, соёл, урлагийн газрын монгол хэл, казах хэл, бага боловсрол хариуцсан мэрэгжилтнүүд зэрэг 553 хүн хамрагдсан болно.

Судалгааны ажлаа 2 чиглэлээр явуулсан. Үүнд:

1. Баримт бичгийн судалгаа
2. Санал асуулга, ярилцлага хийх (судалгааны ажилд оролцогчдоос мэдээллэл цуглуулах)

Баримт бичгийн судалгаа

а. Хууль

“Хос хэлний боловсролын талаарх бодлогын хэрэгжилт, зохицуулалтад хийсэн мониторинг судалгааны ажлын хүрээнд Монгол Улсад амьдарч буй үндэстний цөөнхийн сурч боловсрох эрх, хос хэл\олон хэлний боловсролтой холбоотой ямар хууль тогтоомж, баримт бичиг байгаа эсэхийг судалж үзлээ. Үүнд:

1. 1992 оны нэгдүгээр сарын 13-ны өдөр баталсан **Монгол Улсын Үндэсний хуулийн** Хоёрдугаар бүлэг, арван дөрөвдүгээр зүйлийн хоёрдугаар заалтад: «Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно.»¹, мөн тус хуулийн Нэгдүгээр бүлэг, наймдугаар зүйлийн хоёрдугаар заалтад: «...хүн амын өөр хэл бүхий үндэстний цөөнх эх хэлээрээ суралцах, харилцах, соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах эрхийг үл хөндөнө.»¹ гэж тус тус зааснаар үндэстний цөөнхийн төрөлх хэл, соёл, уламжлал, шашин, амьдралын хэв шинжийг өвлөн хадгалах, төрөлх хэлээрээ сурч боловсрох эрхийг Үндсэн хуулийн түвшинд хамгаалан баталгаажуулсан байна.
2. 2015 онд батлагдсан «**Монгол хэлний тухай**» хуулийн тавдугаар бүлэг, 13.1.4-д «суралцагчдын дийлэнх олонх хүн амын өөр хэл бүхий үндэстний цөөнх байвал сургалтыг хос хэлний хөтөлбөрөөр явуулах бөгөөд хос хэлний хөтөлбөрийн агуулгыг батлах²»; 13.1.5-д «үндэстний цөөнх монгол хэл болон эх хэл дээр боловсрол эзэмших, соёл, зан заншлаа өвлөх, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах²»-ыг Боловсрол, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад; мөн тус хуулийн зургаадугаар бүлэг, 21.7.2-т «үндэстний цөөнхийн хэл, монгол угсаатны аман аялгууг судлах, хамгаалах, хөгжүүлэх, гадаад оронд суугаа монгол үндэстнүүд, олон улсын хэмжээнд монгол хэл, бичиг үсгийн хэрэглээ, сургалт судалгааг өргөжүүлэх, дэмжих чиглэлээр бодлого боловсруулж, Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэх²»-ийг Хэлний зөвлөлд тус тус үүрэг болгон заасан байна.
3. 1996 оны 4 дүгээр сард батлагдсан Монгол Улсын “**Соёлын тухай**” хуулийн дөрөвдүгээр зүйлийн 4-т: «эх хэл, бичиг үсэг, ёс заншил, түүх, соёлын уламжлалыг өвлөн хөгжүүлэх³» тухай тусгасан байна. Мөн 19 дүгээр зүйлийн 2 дугаар заалтад «Угсаатан ястны соёлыг ялгаварлан гадуурхах, хавчин хязгаарлахыг хориглоно³.» гэсэн байна.
4. 2002 онд баталсан “**Боловсролын тухай**” хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т «иргэнийг сурч боловсроход үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, хөгжлийн онцлог, эрүүл мэнд, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлан

1 <https://legalinfo.mn/mn/detail?lawId=367>

2 <https://legalinfo.mn/mn/detail/10932>

3 <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16230709374521>

гадуурхахгүй байх, эх хэлээрээ сурч боловсрох тэгш боломж, нөхцөлөөр хангана⁴» (2006 оны нэмэлт өөрчлөлт), мөн 45 дугаар зүйлийн 45.1.8-д (Суралцагчийн эрх, үүрэг) «уламжлалт соёл, зан заншлыг өвлөх, сургуулийн орчинд төрөлх хэлээрээ харилцах⁴»-ыг (2006 оны нэмэлт өөрчлөлт) заасан байна.

5. 2002 онд баталсан «Бага, дунд боловсролын тухай» хуулийн 4 дүгээр зүйлийн (Бага боловсролын агуулга) 4.1.1-д «эх хэлээрээ зөв ярьж, бодол санаагаа ойлгомжтой илэрхийлэх, уншиж, бичиж сургах⁴»; тус хуулийн 5 дугаар зүйлийн (Сүүрч боловсролын агуулга) 5.1.1-д «эх хэл болон гадаад хэл, математик, мэдээлэл зүй, шинжлэх ухаан, эрх зүйн зохих шатны мэдлэг, өөрийн авьяас, чадварт тулгуурлан бие даан амьдрахад шаардлагатай чадвар, дадал эзэмшүүлэх⁵»; мөн 6 дугаар зүйлийн (Бүрэн дунд боловсролын агуулга) 6.1.1-д «эх хэлээрээ утга төгөлдөр найруулж бичих, ярих чадвар, гадаад хэлний зохих мэдлэг эзэмшүүлэх⁵» тухай тус тус заасан байна.
6. Мөн 2016 онд батлагдсан Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2-т хүүхдийн «төрөлх хэл, бичиг үсэг, ёс заншил, түүх соёлын уламжлалыг өвлөн эзэмших⁶» эрхийг хамгаалан баталгаажуулсан байна.

б. Бусад баримт бичиг

1. **«Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого⁷»-ын /2014-2024 он/ 4.4-д «Бүх шатны сургалтыг төрийн албан ёсны хэл, бичгээр явуулж, уламжлалт монгол бичгийн сургалт, хэрэглээг үе шаттай нэмэгдүүлнэ. Суралцагчдын дийлэнх олонх нь хүн амын өөр хэл бүхий үндэстний цөөнх байвал эх хэлээрээ бага боловсрол эзэмших нөхцөл, боломжоор хангаж, хос хэлний сургалтын бодлого, хөтөлбөр хэрэгжүүлнэ.» хэмээ**
2. Монгол Улсын Засгийн Газрын **“Казах хүүхдийн боловсролын үйлчилгээний чанарыг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай”** 2010 оны 66 дугаар тогтоол;
3. **“Хөтөлбөрт өөрчлөлт оруулж, төлөвлөгөө батлах тухай”** 2010 оны 03 сарын 19 өдрийн 106 тоот тушаалаар батлагдсан **“Баян-Өлгий аймгийн боловсролын үйлчилгээний чанарыг сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний дагуу Боловсролын Хүрээлэнгийн захирлын 2011 оны 9 дүгээр сарын 06-ны өдрийн 16 тоот тушаалаар Боловсролын Хүрээлэнгийн бүтцэд Казах хүүхдийн боловсролын судалгааны сектор байгуулагдсан байна.**
4. Үндэстний цөөнхийн сурч боловсрох эрхийг хангаж, хамгаалах чиглэлээр тусгайлан гаргасан бодлогын баримт бичиг нь БСШУЯ-наас дунд хугацаанд буюу 2006-2012 онд хэрэгжүүлэхээр баталсан **“Казах хүүхдийн боловсролыг**

4 <https://legalinfo.mn/mn/detail/9020>

5 <https://legalinfo.mn/mn/detail/72>

6 <https://legalinfo.mn/mn/detail/11709>

7 <https://legalinfo.mn/mn/detail/10935>

8 <https://news.mn/r/522792/>

дэмжих хөтөлбөр” байна.

- Монгол улсын Засгийн газраас баталсан “Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр” (2017-2021);
- БСШУ-ын сайдын тушаалаар баталсан “Хүүхдэд ээлтэй сургуулийг хөгжүүлэх бодлого”;
- Монгол Улсын Засгийн газраас 2007 онд баталсан “Цаа бугын аж ахуйг сэргээх, цаачдын амьдралын түвшинг сайжруулах хөтөлбөр” зэрэг баримт бичигт үндэсний цөөнхийн хүүхдүүдийн сурч боловсрох эрхийг хангах, тэдний онцлог хэрэгцээнд тохирсон сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх талаар тусгасан байна.

Өнөөгийн байдлаар Монгол Улсын Үндсэн хууль, болон бусад 5 хууль, УИХ-ын Тогтоолоор баталсан 3 хөтөлбөр, Засгийн газрын тогтоолоор баталсан 7 хөтөлбөрт тус тус үндэсний цөөнхийн асуудлаар зарим заалтыг оруулснаар үндэсний цөөнхийн эх хэлээрээ сурч боловсрох, соёл зан заншлаа өвлүүлэх эрхийг ерөнхий хүрээнд нь баталгаажуулжээ.

Мөн үндэстний цөөнхийн хүүхдийн сурч боловсрох эрхтэй холбоотой дараах баримт бичгүүдийг нэрлэж болно. Үүнд:

- “Хүний эрхийн түгээмэл тунхаглал” (1948);
- “Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай” олон улсын пакт” (1966);
- НҮБ-ын Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны байгууллагын “Боловсрол дахь ялгаварлалын эсрэг конвенци” (1960);
- “Үндэс угсаа, арьс өнгөөр ялгаварлахын эсрэг тунхаглал” (1970);
- “Хүний эрх, ардчилалыг хамгаалахад чиглэгдсэн боловсролын хүрээг тодорхойлсон тунхаглал” (1995);
- “Соёлын ялгаатай байдлын талаарх түгээмэл тунхаглал” (2002) гэх мэт.

Эдгээр баримт бичгүүдэд ерөнхийдөө үндэстний цөөнхийн хүүхдийн сурч боловсрох эрхийг хамгаалахад чиглэсэн заалтууд тусгагдсан байдаг. Харин Монгол Улсад амьдардаг үндэстний цөөнхийн хүүхдийн төрийн хэл болон эх хэлээ зэрэг эзэмших буюу хос хэлний боловсролын асуудлыг хөндсөн тусгайлсан баримт бичиг байхгүй байна.

II.Хууль (бодлого)-ын хэрэгжилт

Судалгааны ажлын хүрээнд үндэстний цөөнхийн хүүхдийн сурч боловсрох эрх хуулийн хүрээнд баталгаажсан боловч, бодлогын хэрэгжилт нь ямар түвшинд байгааг тодруулахыг зорилоо.

«Та үндэстний цөөнхийн сурч боловсрох эрх болон хос хэлний боловсролтой холбоотой баримт бичиг, хууль тогтоомжоос нэрлэнэ үү?» гэсэн асуултад судалгаанд хамрагдсан 553 хүний 13 нь буюу 2,4 хувь нь Үндсэн хууль болон Монгол хэлний

тухай хуулийг (2 хүн 2 хуулийг зэрэг нэрлэсэн бол, бусад нь зөвхөн Үндсэн хуулийг нэрлэсэн) нэрлэсэн байна.

Нийт хүн амын 75.6% нь казах үндэстэн болох Баян-Өлгий аймгийн ерөнхий боловсролын төрийн өмчийн 37, төрийн бус өмчийн 6, нийт 43 сургуулийн 2 нь сургалтаа монгол хэлээр (аймгийн төвийн 2-р БДС, Алтай сумын Улаанхад багийн бага сургууль), 6 сургууль сургалтаа монгол, казах зэрэгцсэн бүлэгтэйгээр (Алтай, Алтанцөгц, Булган, Бүянт сумын БДС, Цагааннуурын 9 жилийн сургууль, Булган сумын Шүвтэр багийн бага сургууль), 13 сургууль казах хэлээр (бага сургууль), 1 сургууль монгол-турк хэлээр, 1 бага сургууль тува, монгол хэлээр, 22 сургууль казах, монгол хэлээр сургалтаа зохион байгуулж байна.

Баян-Өлгий аймгийн ерөнхий сургуулиудын өнөөгийн байдал:

1. Эдгээр сургуулиуд нь (аймгийн төвийн 2-р БДС, Алтай сумын Улаанхад багийн бага сургууль, ЭМПАТИ сургуулиас бусад нь) хос хэлний сургалттай сургууль гэж нэрлэгддэг боловч, үйл ажиллагааны хувьд тийм биш байна.
2. Сургалтын төлөвлөгөө, цагийн ачаалал
 - Жилийн сургалтын төлөвлөгөөг салбарын сайд батлах ёстой боловч, Баян-Өлгий аймгийн жилийн төлөвлөгөөг БСУГ-ын дарга баталж байна. Энэ нь «Бага, дунд боловсролын тухай» хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-д заасан “Ерөнхий боловсролын сургуульд мөрдөх сургалтын төлөвлөгөөг боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага боловсруулж, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хянаж, батална¹⁰” гэсэнтэй зөрчилдөж байна.
 - Баян-Өлгий аймгийн сургуулиудад эх хэл, уран зохиолын цаг нэмэгдэхээр хүүхдийн өдрийн, долоо хоногийн ачаалал нэмэгдэнэ. Гэхдээ сүүлийн 30-40 жилийн турш дунд ангид долоо хоногт эх хэл (казах, тува хэл) 2, уран зохиол 2 цагаар ордог байсан. 2019-2020 оны хичээлийн жилээс эхэлж дунд ангийн эх хэлний 1 цагийг «Багш зохицуулах цаг» болгосон. Зарим сургуулийн удирдлагууд үүнийг зөвшөөрөөгүй болохоор, долоо хоногт 2 цаг ордог казах уран зохиолын хичээлийн нэг цаг нь хоригдсон. (аймгийн төвийн 3, 4, 5 дугаар сургууль, Баяннуур сумын БДС гэх мэт). Үүнээс болж багш нарын цаг нь хоригдож, багшийн үндсэн цагийг давтлага, сонгон суралцах хичээлээр дүүргэж байна. Казах хэл дээр унших уран зохиолын ном, гарын авлага, сургалтын нэмэлт материалууд түн ховор, бараг байхгүй болохоор, сурагчид үндэсний онцлогтой холбоотой бүх мэдээллийг хэл, уран зохиолын хичээлүүдээр дамжин авдаг нөхцөлд цагийн хорогдол чухал асуудал болж байна.
 - Хувийн хэвшлийн сургуулиудад эх хэл, уран зохиолын хичээл 1-2 цаг л орж байна.
 - Нийт сурагчдын 60-65 хувийг казах хүүхдүүд бүрдүүлж байгаа аймгийн 2 бүрэн дунд сургууль, хувийн хэвшлийн Эмпати сургуульд хүүхэд эх хэл дээрээ бичиг үсэг танихаар эх хэлний дугуйлан ч явагдахгүй байна.

10 www.legalinfo.mn/law/details/72

- Бага ангийн монгол хэлний цаг маш их байна. Долоо хоногт 5-7 цаг ордог боловч, арга зүй, хөтөлбөр, сурах бичиг, багшийн үр чадвар зэргээс шалтгаалж, үр дүн багатай, нэр төдий болж байна. Энэ нь тоо биш, чанар чухал болохыг харуулж байна. Судалгаанд хамрагдсан 12 дугаар ангийн сурагчид бүгдээрээ 2 дугаар ангиас эхэлж монгол хэлний хичээл орж байсныг хэлэхийн хамт, 95 хувь нь «Та монгол хэл таны хувьд чухал болохыг хэддүгээр ангиас эхэлж ухаарч, монгол хэлийг зорилготой сурч эхэлсэн бэ?» гэсэн асуултад «8-9 дүгээр ангиас эхэлж ухамсарлаж, монгол хэл сурахад анхаарлаа хандуулж эхэлсэн» гэж хариулсан байна. Мөн «Та монгол хэлний хичээлийг хэддүгээр ангиас эхэлж орвол, чанартай, үр дүнтэй явагдана гэж боддог вэ?» гэсэн асуултад 93 хувь нь «5-6 дугаар ангиас эхэлж орох нь зөв» хэмээн хариулсан байна. Сурагчдын энэхүү хариулт нь анхаарал татаад байна.
- Гэхдээ судалгаанд оролцсон багш, эцэг эхчүүдийн 97 хувь нь «Монгол хэлний хичээл 2 дугаар ангиас эхэлж орох нь зөв, учир нь хүүхэд нэг үгийг ч гэсэн эртнээс сонсож, цээжлэх болно» гэж хариулсан байна.

3. Сургалтын хөтөлбөр, удирдамж

- 2013 онд бага ангийн эх хэлний (казах, тува) хөтөлбөр, суралцахуйн удирдамж хэвлэгдэж, өнөөг хүртэл сургалтын үйл ажиллагаанд хэрэгжиж байна.
- 2018 онд суурь боловсролын эх хэлний (казах, тува) хөтөлбөр, суралцахуйн удирдамж боловсруулагдаж, тува хэлний хөтөлбөр хэвлэгдсэн. Казах хэлний суурь боловсролын хөтөлбөрийг принтерээр хэвлэж, багш нарын гарт тарааж өгсөн. Эх хэлний хөтөлбөр сүүлийн 30 жилд анх удаа боловсруулагдаж, сургалтад хэрэгжиж байгаа нь энэ.
- Бүрэн боловсролын тува хэлний хөтөлбөр, суралцахуйн удирдамж боловсруулагдаж, хэвлэгдсэн (2019 онд). Бүрэн боловсролын казах хэлний хөтөлбөр, суралцахуйн удирдамж байхгүй байна.
- Монгол хэлний хичээл казах, тува хүүхдүүдэд 2 дугаар ангиас эхлэн орж байна. Нэг ч монгол үг мэддэггүй сурагчдын хувьд гадаад хэл гэсэн үг. Гэхдээ өнөөг хүртэл үндэстний цөөнхийн хүүхдүүдийн бага ангид зориулсан монгол хэлний хөтөлбөр байхгүй байна.

Боловсруулагдаж, хэвлэгдсэн эх хэлний бүх сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамжийн бүх санхүүжилтийг НҮБ-ын Хүүхдийн сан хийсэн болно.

4. Арга зүй

- Сүүлийн 30 жилд эх хэлний сургалтын хөтөлбөр шинээр боловсруулагдаж удаагүй байгаа болохоор, эх хэлний хичээлийг заах арга зүй мөн адил шинэчлэгдээгүй байна. Казах хэлний хичээлийн хувьд зөвхөн онол заадаг. Эх дээр ажиллах, эхийн задлал хийх гэх мэт хэл бичгийн хичээлүүдийг заах орчин үеийн аргууд нэвтрээгүй байна. Энэ тал дээр Боловсролын хүрээлэнгийн Үндэстний цөөнх болон гадаад дахь монгол хүүхдийн боловсролын судалгааны сектораас жилд нэг удаа зохион байгуулдаг

казах, тува хэлний багш нарт зориулсан сургалтаас өөр ямар ч сургалт, семинар, зөвлөгөө байхгүй байна.

- 2 дугаар ангиас эхлэн орж буй монгол хэлийг казах, тува хүүхдүүдэд заах тусгайлсан арга зүй байхгүй.
 - 2-5 дугаар ангид дөнгөж монгол хэлний анхан шатны мэдлэг авч байгаа сурагчид 6 дугаар ангид орж эхлэхэд бүх ном, сурах бичиг монгол хэл дээр, бүх хичээл монгол хэл дээр орно. Шинжлэх ухааны үг хэллэг, сурах бичиг сурагчдад хүндээр тусаж байна. 6-7 дугаар ангид, бага ангиас дунд ангид шилжих үед тусгайлсан арга зүй байхгүй. Үүнээс болж сурагчдын сурлагын амжилт огцом унах, бэрхшээж цаашид сурах хүсэлгүй болох гэх мэт маш олон сөрөг үр дагавартай байна. Тухайлбал, 6 дугаар ангийн сурагч математикийн дөрвөн үйлдлийг монгол хэл дээр нэрлэж чадахгүй байгаа болохоор, математикийн хичээлд тоо бодох ямар ч боломжгүй болж байна. Зааж байгаа хичээлээ сурагчид ойлгохгүй байгааг анзаарч, ойлгосон багш монголоор заасан хичээлээ дахиад эх хэл дээрээ орчуулж заана. Энэ нь маш их цаг авахын хамт багш дунд ангид казах хэлээр хичээл зааж байна гэсэн шүүмжлэлд бас өртөж байна.
5. Эх хэл болон монгол хэлний сургалтын чанар
- Манай судалгаанд оролцогчид «Эх хэлний мэдлэг, чадвар ахих тусам монгол хэлний чадвар ахидаг» гэж үзсэн байна. Гэхдээ сүүлийн жилүүдэд эх хэлний сургалтын чанар, багш сурагчдын эх хэлний сургалтад хандах хандлага суларч байна.
 - Хүүхэд хамгийн эхэнд эзэмшдэг эх хэлний унших, бичих, ярих, сонсох чадвар тааруу болохоор, түүнийг дагаад, дээр нь хөтөлбөргүй, сурах бичиггүй, тусгай арга зүйгүй, багшийн мэдлэг, чадвар дутмаг монгол хэлний сургалтын чанар муу байна.
6. Багш нарын мэдлэг, чадвар, мэргэжил дээшлүүлэх
- Баян-Өлгий аймгийн 43 сургуульд ажиллаж буй бага ангийн 500 багшийн 70 хувь нь Ховд Их сургуулийн Баян-Өлгий аймаг дахь салбар сургуулийн, бусад нь Архангайн Багшийн сургууль, МУБИС, Казахстаны их, дээд сургуулийн төгсөгчид байна.

Үүнд Казахстан, ОХУ-аас мэргэжил эзэмшсэн багш нарын хувьд монгол хэл заах арга, дидактикийн хичээл; Монголын их, дээд сургууль төгсөгчдийн хувьд казах хэл заах арга зүй, дидактик судлаагүй болохоор, аль аль нь ч хос хэлээр хичээл заах чадвар дутмаг. Дээр нь бүрэн дунд сургуулийг амжилттай төгсөгчид гадаад дотоодын шилдэг их, дээд сургуульд суралцахаар явж, орон нутагт дунд түвшний төгсөгчид үлддэг нь үнэн. Тэгэхээр бага ангийн багш нарын суурь боловсрол, эх хэл болон монгол хэлний мэдлэг, чадвар сул байгаа нь ойлгомжтой.

- Бага ангийн багш нарын эх хэлний мэдлэг, чадварын түвшин өөрөө сурагч байхдаа эзэмшсэн 8-9 дүгээр ангийн казах, тува хэлний түвшингээрээ байна. Багш бэлтгэх сургуульд казах, тува хэлний хичээл ороогүй. Хэрэв

багш өөрөө ерөнхий боловсрол монгол сургуульд эзэмшсэн бол, огт казах, тува хэл заалгаж байгаагүй гэсэн үг. Казах, тува хэлний шинжлэх ухааны ямар ч мэдлэггүй байсан ч одоо сурагчдад казах, тува хэл зааж байна.

- Тува, казах хэлний мэргэжлийн багш нарын хувьд Монгол Улсад мэргэжил дээшлүүлэх боломжгүй. Боловсролын хүрээлэнгийн Үндэсний цөөнх, гадаад дахь монгол хүүхдийн боловсролын судалгааны сектор байгуулагдсанаас хойш уг асуудлаар нэлээн ажилласны үр дүнд казах, тува хэлний мэргэжлийн багш нар монгол хэлний мэргэжлийн багш нарын хамт 5, 10, 15 жилийн үндэсний сургалтад хамрагддаг болсон. Гэхдээ Тува, Казахстан улсад мэргэжил дээшлүүлэх боломж байна, хамгийн гол нь эрх бүхий байгууллагуудын хамтын ажиллагаа, гэрээ, хэлэлцээр хэрэгтэй байна.
- Хос хэлээр бэлтгэгдсэн багш байхгүй.

7. Сурах бичгийн асуудал

Сурах бичгийн талаар 2 чиглэлээр ярьж болно.

1. Сурах бичгийн хангамж, хүртээмжийн асуудал:

- Сурах бичгийн хангамж, хүртээмж маш муу. Ялангуяа ахлах ангийн хувьд 30-35 хувийн хүрэлцээтэй байна. Удахгүй их, дээд сургуульд элсэхээр бэлтгэж буй сурагчдын хувьд энэ маш том бэрхшээл болж байна.
- Зарим сурах бичиг маш хуучирч, элэгдсэн.

2. Сурах бичгийн агуулга, чанарын асуудал:

- Бага ангийн Казах хэлний сурах бичиг (1-5 дугаар анги) 2019 онд шинээр хэвлэгдсэн.
- Бага ангийн Тува хэлний сурах бичиг (1-5 дугаар анги) НҮБ-ийн Хүүхдийн сангийн санхүүжилтээр 2013 оноос эхэлж, багш, сурагчийн номтойгоо хэвлэгдсэн гарын авлага байна.
- 1 дүгээр ангийн 4 сурах бичиг тува хэлэнд, 1-5 дугаар ангийн 29 сурах бичиг казах хэлэнд орчуулагдсан байна. Сурах бичгийн орчуулгын чанар тусдаа яригдах сэдэв болоод байна.
- Хөгжим, дүрслэх урлаг, түүх зэрэг үндэсний онцлогийг харуулдаг хичээлүүдэд нэмэлт сурах бичиг хэрэгтэй байна. Тухайлбал, казах, тува аялгуу, дууны түүх, онцлог зэргийг харуулсан нэмэлт сурах бичиг байхгүй, монгол сурах бичгийн орчуулга байна.
- Дунд ангийн Казах хэлний сурах бичиг нь 2018 оноос өмнө хэвлэгдсэн болохоор шинэ сургалтын хөтөлбөртэй нийцэхгүй. Түүнчлэн, казах хэл болон уран зохиол хичээлүүдийн сурах бичиг дундаа ганц ном (170 хуудас) байдаг учир сэдэв бүр нь 2-3 даалгавар байдаг, маш цөөн тооны, хязгаарлагдмал агуулгатай байна.
- 2, 3, 5 дугаар ангид НҮБ-ийн Хүүхдийн сангийн санхүүжилтээр хэвлэгдсэн

Монгол хэлний гарын авлагаар хичээл ордог бол 4 дүгээр ангид гарын авлага огт байхгүй. 2019 онд 3 дугаар ангийн гарын авлага нэмэлт захиалгаар дахин хэвлэгдэхэд тодорхой бус шалтгаанаар багшийн ном, сурагчийн ном 2-ын тоо солигдож хэвлэгдсэнээс болж, багшийн ном нь 2000 ширхэг, сурагчийн ном нь багшийн тоогоор хэвлэгдэж, одоо сурагчдад хүрэлцэхгүй, элэгдсэн, урагдсан хуучин номоор хичээллэж байна.

- Бага ангийн бүх сурах бичиг хүрэлцээгүй, дутуу байна.
8. Гарын авлага, нэмэлт материал, зөвлөмж, сургалтын хэрэглэгдэхүүн
- Дунд, ахлах ангийн монгол хэлний хичээлийн хувьд үндэсний хэмжээний зөвлөмж, гарын авлага, нэмэлт материалууд хэрэглэгдэж байна.
 - Түүнчлэн 2012 онд Баян-Өлгий аймгийн ЕБС төгсөгчдийн монгол хэлний ЭЕШ-ын гүйцэтгэлд хийсэн шинжилгээний дүнг үндэслэн Боловсролын хүрээлэнгийн Казах хүүхдийн боловсролын судалгааны сектороос (тухайн үеийн нэршил) казах, тува хүүхдүүдэд монгол хэл заах багш нарт зориулсан анхны арга зүйн зөвлөмжөө боловсруулан гаргасан. Энэхүү номонд дунд, ахлах ангид монгол хэлний эх, өгүүлбэрзүй, үгзүй, үгийн сан, найруулгазүй, зөв бичгийн болон монгол бичиг, уран зохиолын даалгавартай ажиллах аргачлал, казах, тува хүүхдэд монгол хэл заахад болон сорил ажиллахад анхаарах зарим зөвлөгөөг багтаасан болно. Тус зөвлөмжийг боловсруулах, хэвлэн нийтлэхэд НҮБ-ын Хүүхдийн сан санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байна.
 - Бага ангийн сурагчдын хувьд үндэсний хэмжээний ном, гарын авлага хүнд байна. Үндэстний цөөнхийн бага ангийн сурагчдын хэрэгцээ, сонирхолд нийцсэн монгол хэлний гарын авлага, зөвлөмж зэрэг нэмэлт материал огт байхгүй.
 - Дунд, ахлах ангийн багш, сурагчдад зориулсан эх хэлний зөвлөмж, гарын авлага, нэмэлт материал огт байхгүй. Зарим багш нар Казахстан Улс руу захиалж нэмэлт хэрэглэгдэхүүн, гарын авлага авхуулж, сургалтад хэрэглэж байна.
 - 2018 онд Боловсролын хүрээлэнгээс эрхлэн гаргасан «Бага ангийн сурагчдын унших чадварыг хөгжүүлэх, үнэлэх зарим арга, хэрэгсэл» гарын авлагыг 2019 онд Үндэсний цөөнх, гадаад дахь монгол хүүхдийн боловсролын судалгааны секторын эрдэм шинжилгээний ажилтнаар ахалсан ажлын хэсэг казах хэлэнд орчуулж, Баян-Өлгий аймгийн бага ангийн 500 багшид тарааж өгсөн. Уг номыг сүүлийн 25-30 жилд бага ангийн багш нарт зориулан эх хэл дээр гарсан анхны гарын авлага гэж үзэж болно.

Уг гарын авлагын дагуу 2019 онд бага ангийн багш нарт зориулсан сургалт зохион байгуулагдав. Энэхүү сургалтад Баян-Өлгий аймгийн бага ангийн 500 багш хамрагдсан.

Манай судалгааны ажилд тус сургалтад хамрагдсан бага ангийн багш оролцсон бөгөөд эх хэл дээр мэргэжлээ дээшлүүлсэн байдлаа ийнхүү ярьсан байна:

Би 25 жил бага ангийн багшаар ажиллав. Архангайн багшийн сургууль төгссөн. 25 жил ажиллахдаа өнгөрсөн намар анх удаа казах хэл дээр явагдсан сургалтад суулаа. «Бага ангийн сурагчдын унших чадварыг хөгжүүлэх, үнэлэх зарим арга, хэрэгсэл» нэртэй сургалт байсан. Эх хэл дээр явагдсан сургалтад суух их гоё мэдрэмж төрүүлдэг юм байна. Өөр казах хэл дээр явагдсан сургалт, семинарт оролцож байгаагүй.

Аймгийн төвийн 4 дүгээр БДС-ийн бага ангийн багшийн ярилцлагаас

Бага ангийн багш нарт зориулан эх хэл дээр хэвлэгдэн гарсан дараагийн бүтээл бол «Бага боловсролын эх хэлний судлагдахууны сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих багшлах арга зүйн зөвлөмж» (казах, тува хэл дээр) 2020 онд хэвлэгдэж, бага ангийн багш нарын хүртээл болж байна. Ийнхүү багш, сурагчдад зориулсан эх хэл дээр хэвлэгдсэн гарын авлага, нэмэлт материалын тоо нэмэгдэж байгаа нь сайшаалтай байна.

- Үндэстний цөөнхийн хүүхдүүдийн төрийн хэлийг сурахад онцын шаардлагатай зүйлийн нэг нь монгол, казах, тува хэлний толь бичиг юм. 1984 онд хэвлэгдсэн доктор Б.Базылхан гуайн «Монгол-казах толь»-иос өөр толь бичиг байхгүй байна. Тус толь бичиг маш ховор, байгаа нь үнэтэй болж байна.
- Тусгайлсан судлагдахууны шинжлэх ухааны нэр томъёоны толь бичиг маш шаардлагатай боловч, одоохондоо байхгүй байна.

III.Бусад

а. Сүүлийн 10 жилд хийгдсэн судалгаа

Судалгаанд хамрагдсан багш, сурагч, эцэг эхчүүдээс үндэстний цөөнхийн хүүхдүүдийн боловсролын талаар явагдсан судалгааны ажлын талаар сонсож байсан эсэхийг асуухад 4 сургуулийн багш нар Боловсролын хүрээлэнгийн ҮЦГМХБСС-аас явагдсан судалгааны ажлын тайлантай танилцаж байснаа дурдсан байна.

- Хүний Эрхийн Үндэсний Комисс: “Казах, тува хүүхдүүдийн сурч боловсрох эрх, хөдөлмөр эрхлэлтийн байдал” /2010/
- “Үндэсний цөөнх цаатан хүүхдүүдийн сурч боловсрох эрхийн байдал” төсөл /2010/

Боловсролын хүрээлэнгийн ҮЦГМХБСС-аас явуулсан судалгаа:

- “Секторын үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох судалгаа” (меташинжилгээ) \2011\;

- “Хос хэлээр сургалт явуулдаг 12 жилийн ерөнхий боловсролын сургуулийн сургалтын төлөвлөгөө” \2012\;
- “Баян-Өлгий аймгийн сургуулийн өмнөх боловсролын насны хүүхэд болон ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын тоо, байршлыг угсаатны бүлгээр тогтоох” \2012-2015\;
- “Баян-Өлгий аймгийн ЕБС төгсөгчдийн монгол хэлний хичээлийн элсэлтийн ерөнхий шалгалтын дүнд хийсэн шинжилгээ” \2012\;
- “Баян-Өлгий аймгийн ЕБС-ийн бага ангийн эх хэлний түвшинг тандах” \2013\;
- “Баян-Өлгий аймгийн ЕБС-ийн сурах бичгийн хүрэлцээ, хангамж” (жил бүр);
- “Баян-Өлгий аймгийн ЕБС-ийн багш нарын мэргэжил дээшлүүлэх хэрэгцээ” \2014\;
- “Хос хэлээр сургалт явуулдаг сургуулийн бага ангийн монгол хэлний сургалтын үр дүнг тандах” \2014\;
- “Орчуулгын сурах бичгийн чанар” \2015\;
- “Хос хэлээр сургалт явуулдаг ЕБС-ийн суурь боловсролын эх хэл болон монгол хэлний сургалтын үр дүнг тандах” \2016\;
- “Хос хэлээр сургалт явуулдаг ЕБС-ийн бага боловсролын эх хэл болон монгол хэлний сургалтын үр дүнг тандах” \2016-2017\;

б. Түншлэл

Үндэстний цөөнхийн сурч боловсрох асуудалд анхаарал тавьж, дэмжлэг туслалцаа үзүүлж байдаг төрийн эрх барих байгууллагуудын хамт НҮБ-ийн Хүүхдийн сан, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк зэрэг олон улсын байгууллагууд их хэмжээний оюуны хөрөнгө оруулалт хийж, санхүүгийн дэмжлэг үзүүлж байна. Түүнчлэн, судалгаа, мэдээллээр хангах чиглэлээр санаачлагатай ажиллаж буй төрийн бус байгууллага «Бүх нийт боловсролын төлөө!» иргэний нийгмийн үндэсний эвсэл юм.

«Монгол Улсад амьдарч буй үндэстний цөөнхийн төлөөллийн хувьд та юугаар бахархаж, юунд илүү их санаа зовдог вэ?» гэсэн асуултад судалгаанд оролцогчдын ихэнх нь «1. Эх орноороо; 2. Эрх чөлөөгөөрөө; 3. Үндэстний хэл, соёл, ёс заншлаараа бахархана» гэсэн байна. «1. Олон нийтийн сүлжээ нь дэхь ялгаварлан гадуурхалт, доромжлол; 2. 5-10 жилийн дараа үр хүүхдүүд маань үндэсний эх хэл, соёлоо алдах вий гэхээс; 3. Боловсролын салбарын тулгамдаж буй асуудал шийдэгдэж, төрийн хэлний мэдлэг чадвар дээшлэхгүй байгаад санаа зовж, эмзэглэж байна» гэж хариулсан байна.

ХОТ СУУРИЙН ГАЗАР АМЬДАРЧ БУЙ КАЗАХ ИРГЭДИЙН ЭХ ХЭЛНИЙ ХЭРЭГЛЭЭГ СУДЛАХ ОНЛАЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

АГУУЛГА

Нэг. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, АРГА ЗҮЙ

- I.1 Судалгааны зорилго, зорилт, арга зүй*
- I.2 Судалгааны түүвэрлэлт, тоо хэмжээ*
- I.3 Мэдээлэл боловсруулж, дүн шинжилгээ хийсэн арга, аргачлал*

ХОЁР: СУДАЛГААНЫ ҮНДСЭН ҮР ДҮН

- II.1 Хот, суурин газар суурьшсан казахуудын тухай товчхон*
- II.2 Судалгааны үндсэн дүн*
- II.3 Дүгнэлт*

UIH.MN
СУДАЛГААНЫ САН


Нэг СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, АРГА ЗҮЙ

I.1 Судалгааны зорилго, зорилт, арга зүй

Монгол улсын Үндсэн хуулийн 8.2-т хүн амын өөр хэл бүхий үндэстний цөөнх эх хэлээрээ суралцах, харилцах, соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах эрхийг үл хөндөнө гэж заасан байдаг. Хот суурин газар амьдарч буй казах иргэдийн эх хэлний хэрэглээг судалсан албан судалгаа одоогоор байхгүй байна.

Тиймээс хот суурин газар амьдарч буй казах иргэд эх хэлээ сурч, мэдэж, харилцаж, соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаанд хэрхэн ашиглаж буй болон тэдний эх хэлний хэрэглээг тандан судлахыг зорьсон болно.

Зураг 1.1. Судалгааны арга зүй



Судалгааны ажлын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн болно. Үүнд:

- ✓ Судалгааны арга зүй, дизайн, асуулгын хуудас бэлтгэх;
- ✓ Тоон болон чанарын судалгаан мэдээлэл цуглуулах, ажлын талбарт хэрхэн хийх талаар зөвлөлдөх, зөвлөгөө өгөх;
- ✓ Хүн амын өргөн хэрэглэдэг цахим сүлжээний фэйсбуук (facebook)-ыг ашиглан судалгаанд оролцогчдыг тогтоох, санамсаргүй түүврийн аргаар оролцогчоо сонгох, өөрсдийн танил, фэйсбүүк нийгмийн олон нийтийн сүлжээний оролцогч руу шууд хандах зэргээр оролцогчдоо тогтоох;
- ✓ Цуглуулсан мэдээллээ боловсруулах, дүн шинжилгээ хийх, тайлан бичих зэрэг болно.

I.2. Судалгааны түүвэрлэлт, тоо хэмжээ

Бидний судалгаа КОВИД-19 цар тахлын үеийн хөл хорионы үед таарсан тул биеэр уулзалдах, хамтран ярилцах, биечлэн зөвлөгөө өгөх боломжгүй, утас болон интернет хүрээнд л хязгаарлагдаж хийгдсэнээрээ онцлогтой байв.

Судалгааны мэдээллийг гүүгл форм (google forme)-ыг ашиглан авсан бөгөөд баримт бичгийн шинжилгээ хийх аргаар, утсаар холбогдож биечлэн асуух, тодруулах замаар хийлээ.

Зураг 1.2. Түүврийн тоо хэмжээ

Хамрах хүрээ:
Улаанбаатар хот- 100 асуулга
Шарын гол- 50 асуулга
Налайх- 100 асуулга
Дархан, Эрдэнэт, Сэлэнгэ- 100 асуулга
Анх НИЙТ: 300 асуулга
Сүүлд: 383 оролцогч

Анх бид схем I.2-т заасны дагуу 300 хүнээс судалгаа авахаар төлөвлөсөн боловч оролцогсод идэвхтэй байсан тул 383 хүн судалгаанд хамрагдлаа.

I.3. Мэдээлэл боловсруулж, дүн шинжилгээ хийсэн арга, аргачлал

Асуумжийн тоон мэдээллийг боловсруулалт хийж, хагас бүтэцлэгдсэн буюу зарим асуултын хариултыг өөрөө бичих боломжтой байдлаар хариулсан задгай асуултуудыг контент анализ буюу агуулгын шинжилгээ SPSS 23.0 программ ашиглан боловсруулсан бөгөөд хүснэгт, графикаар илэрхийллээ.

Эл судалгааны хүрээнд асуумжаа гүүгл форм ашиглаж боловсрууллаа.

Асуумж Нийт 4 үндсэн хэсэг, 28 асуулттай.

1. Хувийн мэдээлэл -7 асуулттай

- нас
- үндэс угсаа
- хүйс
- боловсролын түвшин
- мэргэжил
- оршин суугаа газар
- тэнд амьдраад хэдэн жил болж байгаа талаархи асуулт

2. Хэлний өдөр тутмын хэрэглээ- 7 асуулттай

- эх хэл нь ямар хэл болох
- өдөр тутамдаа ямар хэлээр харилцдаг
- монгол хэлийг өдөр тутамдаа хэр их хэрэглэдэг
- казах хэлийг өдөр тутамдаа хэр их хэрэглэдэг
- казах хэлийг хэрхэн сурсан
- казах хэлийг анх хэрхэн сурсан
- өдөр тутмын хэлний хэрэглээний талаарх асуулт

3. Хэлний чадвар- 3 асуулттай

- казах хэл мэддэг эсэх
- монгол хэлний мэдлэгийн чадвараа үнэлэх
- казах хэлний мэдлэгийн чадвараа үнэлэх тухай асуулт

4. Харилцааны орчин- 11 асуулттай

- асуултаа заасан хүмүүстэй ямар хэлээр харилцдаг
- заасан тодорхой орчинд ямар хэлийг хэрэглэдэг
- заасан нөхцөлд ямар хэлийг хэрэглэдэг
- хос хэлээр харилцдаг нөхцөлийг тодруулах
- заасан нөхцөлд ямар хэлийг голлон хэрэглэж байсан
- казах хэл сурахыг хүсдэг эсэх
- эх хэлээ мэддэггүйдээ санаа зовнидог эсэх
- орон нутагт нь казах хэлний дугуйлан, секц байдаг эсэх
- эх хэлээ сурч мэдэхэд юу хийх хэрэгтэйг
- өөрийгээ хос хэлтэн гэж үздэг эсэх
- хос хэлний талаар хэлэх саналыг тус тус асуусан.

Судалгааны линк

- https://docs.google.com/forms/d/e/1FAIpQLScMvxWIZ1nbkqXica5ERlCduSLtqiQU2u16-F8YvAy7HBiong/viewform?usp=sf_link

ХОЁР. СУДАЛГААНЫ ҮНДСЭН ҮР ДҮН

2.1 Хот, суурин газар суурьшсан казахууд

Монголын Казахууд гэхээр ихэвчлэн баруун бүсийн Баян-Өлгий, Ховд аймагт оршин суудаг казахуудын тухай ойлгож, авч үздэг бөгөөд тэдэнтэй холбогдох судалгааны өгүүлэл, ном бүтээл хот, суурин газар төвлөрөн суудаг казахуудыг бодоход харьцангуй элбэг байна. Харин хот, суурин газар төвлөрөн амьдарч буй үндэстний цөөнх казахуудын соёл, зан заншил, хэлний хэрэглээ, түүхэн замналын тухай судалгаа эрдэм судлалын эргэлтэнд ороогүй байгаа бөгөөд бидний хийж буй эл судалгаа анхных нь гэж хэлж болох юм.

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогоор Монгол Улсын харьяат иргэдийн үндэс, угсааны талаарх мэдээллийг нэлээн өргөжүүлэн авч үзжээ. Казахуудын нийт хүн амд эзлэх хувийн жин 3.8 хувь байгаагаараа Халхуудын дараа орж байна. Олон угсаатны өлгий нутаг Ховд аймгийн нийт хүн амын дотор Халх 28.1 хувь, Захчин 25.3 хувь, Казах 11.2 хувь, Урианхай 8.3 хувь, Торгууд 7.4 хувь, Дөрвөд 6.5 хувь, Өөлд 6.1 хувь, Мянгад 5.3 хувь байгаа нь бусад аймгаас онцлог юм. Бүс нутгаар үзэхэд Баруун бүсийн нийт хүн амын дотор Халх 41.0 хувь, Казах 25.8 хувь, Дөрвөд 10.4 хувь, Баяд 7.1 хувь, Захчин 5.6 хувийг эзэлж байна. Казахуудын 77.7 хувь нь Баян-Өлгий аймагт байна гэжээ.¹¹

Хот, суурин газар төвлөрөн амьдарч буй казахуудын хүн амын нэгдсэн тоог одоогоор бүрэн гүйцэд гаргах боломжгүй байна. Учир нь 2020 оны Хүн ам, орон сууцны тооллогын дүн Статистикийн үндэсний хорооны цахим хуудсанд бүрэн байршаагүй байна. Судалгаанд хамрагдсан бүс нутгийн казах иргэдийн тоог Хүснэгт 1.1-т харууллаа. Тэдний хэрхэн, хэдийд нүүж очсон тухайд одоогоор бүрэн, эмх цэгцтэй, нарийн судалгаа мөн алга. Судлаач Х. Дареже “Монголын төрөөс үндэсний цөөнхийн талаар авч хэрэгжүүлсэн бодлого” бүтээлдээ казахууд Сэлэнгэ, Өвөрхангай, Говь-Алтай, Ховд, Дорнод зэрэг аймгуудад барилга барьж, бүтээн байгуултанд их үүрэг гүйцэтгэжээ хэмээн онцлон тэмдэглэжээ. Юун түрүүнд бид Налайх дүүрэгт оршин сууж буй казахуудын тухай товчхон авч үзье.

Казахууд Монгол улсын бүтээн байгуулалт, улс ардын аж ахуйн салбарт ихээр ажиллаж байв.

1926-1930-аад оны үед Налайхын уурхайд ажиллахаар анхны казахууд Налайхад нүүдэллэн иржээ.¹² 1940-өөд оны үед Налайхын уурхайд ажиллахаар казахууд олон тоогоор нүүдэллэн ирсэн бөгөөд уурхайн анхны ажилчин нь казах хүн байжээ.¹³ Налайхын уурхайд 1936, 1938 онд Зөвлөлт Холбоот улсаас 10 гаруй мэргэжилтэн ирүүлсэн бөгөөд мөн онд баруун гурван аймгаас олон тооны ажилчид элсүүлэн авчээ.¹⁴ Эдгээр эх сурвалжаас харахад Налайхад анх 1926-1930-аад оны үед ирж суурьшин эл бүсийн бүтээн байгуулалтанд гар бие оролцсон нь харагдаж байна.

11 Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын нэгдсэн дүн, 51-53-р тал.

12 Батырбек Х, Моңғолиядағы мешіттер (Монгол улс дахь мешит, сүм хийдүүд), УБ, 2020, 48-р тал.

13 Алтангүл Б, Présence des kazakhs en Mongolie, Казахын соёл, зан заншил, УБ, 2017, 60-р тал.

14 <http://www.nad.ub.gov.mn/c/view/56>

1958 оны байдлаар Налайхын нийт уурхайчдын 80% нь казахууд байв.¹⁵ Казахууд Налайх-д нүүдэллэн ирж уурхайн бүтээн байгуулалтад амжилттай оролцсныг доорх хэдэн жишээнээс харж болох юм. “Уурхайчдын амжилтыг өндрөөр үнэлж 1962 онд уурхайн 40 жилийн ойгоор уулын мастер Н.Залиль, малтагч Д.Чанкий, Ж.Батлай нарт тус тус Хөдөлмөрийн баатар цол олгож, 1971 онд Ардын Хувьсгалын 50 жилийн ойгоор А.Орногвой даргатай 3 дугаар хэсгийнхэн хоногийн нэгдсэн бригадын хөдөлгөөнийг тууштай нэвтрүүлж нэг комбайнт лаваас сард 10 мянган тонн нүүрс гаргах нэмэлт үүрэг авч амжилттай биелүүлсэн тул А.Орногвойд Хөдөлмөрийн баатар цол тус тус олгож байв.”¹⁶ Налайхын уурхайгаас Д.Чанкий, Н.Залил, А.Орногвай, Окобал нарын хөдөлмөрийн баатар цолтон, Адрес, Жавлай, Сайполда, Кадас, Ө. Шаравхан, нарын гавьяат уурхайчид, У.Мавлет нарын төрийн шагналтан төрөн гарчээ.¹⁷ Налайхын уурхайгаас 12 хөдөлмөрийн баатар төрснөөс 5 нь буюу 42% хувь казах байгаа нь тэдний хөдөлмөрч чанар, Налайхын уурхайн бүтээн байгуулалтанд оруулсан хувь нэмрийг харуулж буй хэрэг юм. Өнөөдөр Налайх дүүргийн нийт хүн амын 10 гаруй хувийг казахууд эзэлж байна. 1990 онд Монгол улсад ардчилал тогтсон цагаас шашин шүтэх, эс шүтэх явдал чөлөөтэй болсон нь Ислам шашны сүм хийд нээгдэн, казахууд оршин сууж буй газар сүм хийдээ барих, сүсэглэх боломж бүрджээ. 1990 онд Налайхын захиргааны А/67 тушаалаар Монголын Мусульманы Нийгэмлэгийн салбар байгуулагдан, 1993 онд анхны мешит-сүм баригджээ.¹⁸ 2012 онд “Кония-ийн соёлын төв буюу Хазирет Османы мешит” ашиглалтанд орсон бөгөөд Монгол улсад баригдсан сүм хийдийн дотор хамгийн орчин үеийн хэв загвартай, сайхан болсон хэмээн Монголын Мусульманы Нийгэмлэгийн тэргүүн Х.Батырбек “Монгол улс дахь мешит, сүм хийдүүд” бүтээлдээ онцолжээ. Тэрбээр номынхоо эхэнд Казахууд төвлөрөн оршин сууж буй газруудад ислам шашны сүм хийд байгаа гэжээ.

Улс орны уурхайн бүтээн байгуулалттай холбоотой өөр нэгэн нүүдэл суудал одоогийн Дархан-Уул аймгийн Шарын гол, Орхон аймгийн Эрдэнэтийн үйлдвэртэй холбогдож байна. Сэлэнгийн нутаг руу газар тариалангийн салбар болон шинээр байгуулагдаж буй САА-д ажиллахаар ирсэн бололтой. Дархан хотын нийт хүн амын 2612 хүн буюу 2,6%-ийг, Шарын гол сумын 1330 буюу нийт хүн амын 16.3%-ийг казахууд эзэлж байна. 1961 онд МАХН-ын XIV их хурлаар Шарын голын уурхайг түшиглэн Дархан хотыг аж үйлдвэрийн хоёр дахь төв болгон хөгжүүлэхээр шийджээ. Шинэ хотыг байгуулахад Залуучуудын Холбооноос залуусыг ирж ажиллахыг уриалсны дагуу олон казах залуус тэнд очиж ажилласан байдаг.

“Шарын голд нүүрсний уурхай баригдах нам засгийн шийдвэр 1962 оны намар гарч 11-р сард анхны казах иргэд Шарын голд хөл тавьсан юм. Цэргийн алба хаасан Ж. Асиба, Ш. Сейтхожа (Сергазы), Е. Сидам, Х. Хасымхан, Хуаныш, Шарыпхан нар анх ирж байжээ. 1962-1964 онд уурхайн барилга байгууламж баригдаж дуусаагүй учир баригдаж байсан тосгоны барилгын туслах ажилтан, мэргэжилтэй ажилтан бэлтгэх анхны курс нээгдэж Ж. Асиба, Е. Сидам, Т. Хуаныш нар экскаваторчин Ш. Сергазы,

15 Дареже Х, Монголын төрөөс үндэсний цөөнхийн талаар авч хэрэгжүүлсэн бодлого, Өлгий, 2013, 97-р тал.

16 <http://www.nad.ub.gov.mn/c/view/56>

17 idem

18 Батырбек Х, Моңғолиядағы мешиттер (Монгол улс дахь мешит, сүм хийдүүд), УБ, 2020, 48-р тал.

Шарипхан нар краз машины жолооч, Х.Хасымхан бульдозерчний мэргэжил эзэмшин уурхайн анхны мэргэжилтэй ажилчин болсон байна. Энэ хүмүүсийг казах иргэд уурхайн түүхэн дэх анхны 6 хүн гэж хэлдэг юм”.¹⁹ 1964 оны 6-р сарын 17-нд Баян-Өлгий аймгийн намын хорооны 1-р нарийн бичгийн дарга байсан төр, нийгмийн зүтгэлтэн Х. Мусахан уурхайн анхны даргаар томилогдон ирсэн. 1967 онд ЗХУ-д мэргэжил эзэмшсэн Т. Халых анхны казах инженер юм.²⁰ Мөн Шарын гол суманд казахууд олноор суурьшиж амьдрах болсон шалтгаан нь 1970 онд Мод бэлтгэлийн аж ахуй байгуулагдсан явдал юм. Энэ үйлдвэрийн анхны орлогч даргаар Түнхэлээс А. Шөшкей томилогдон ирсэн юм.²¹

Тэгэхээр улс орны бүтээн байгуулалтын он жилүүдэд төв суурин газар нүүдэллэн ирсэн казахууд хэдэн үеэрээ, үр удмаараа тухайн нүүдэллэн очсон бүс нутгийнхаа бүтээн байгуулалтанд гар бие оролцож одоо ч тэндээ амьдарсаар байна. Хот, суурин газар амьдарч буй казахуудыг “ишкер аймақтың қазақтары” буюу “нутгийн гүний казахууд” гэж нэрлэж заншсан. Дархан-уул аймгийн Шарын гол суманд 1996 онд, Хонгор суманд 2007 онд, Эрдэнэт хотод 2016 онд тус тус исламын мешит сүм хийд баригджээ. Хот, суурин газар ислам шашны сүм, хийдийг барьж байгуулж, сүсэгтнүүд шашин чөлөөтэй шүтэх эрхтэй болсон нь үндэстний цөөнх казахууд соёл, зан заншлаа хадгалах, хэл соёлоо сэргээх, авч үлдэх боломж бүрдсэн хэмээн ММН-ийн тэргүүн Х. Батырбек “Монгол улс дахь мешит, сүм хийдүүд” номондоо онцлон тэмдэглэсэн байна.

2.2. Судалгааны үндсэн үр дүн

Тухайн судалгаанд нийт Улаанбаатар хотын Налайх дүүргийг тусгайлан, бусад дүүргүүдийг нэгтгэн, Сэлэнгэ аймаг, Дархан-Уул аймгийн Дархан хот, Шарын гол сум, Орхон аймгийн Эрдэнэт хотод оршин суудаг казахуудын асуумжинд хариулсныг эх сурвалж болгон ашиглалаа.

Дээр дурьдсан хот, суурин газрын Статистикийн газрын гаргасан тоог харгалзан, мөн цахим сүлжээ, тэр тусмаа нийгмийн сүлжээний фэйсбүүк платформ ашигладаг казахуудыг санамсаргүй түүврийн аргаар түүвэрлэн оролцогсдыг сонгон авсан болно.

Хот, суурин газар амьдарч буй казахуудын хүн амын нэгдсэн дүнг гаргахад бэрхшээлтэй байв. Учир нь Статистикийн Үндэсний Хорооны (<https://1212.mn/BookLibrary.aspx?category=001>) цахим хуудсанд 2020 оны ээлжит тооллогын Улаанбаатар хотын дүн хураангуй байдлаар байгаа тул нарийн тоо авах боломжгүй, Налайх дүүрэг, Дархан-Уул аймгийн Дархан хотын 2020 оны тооллогын дүн олдоогүй зэргээс үүдэн казах оршин суугчдын тоог тухайн орон нутгийн статистикийн ажилтнаас авлаа.

19 Дархан Хайрханы өвөр Шарын гол мину, Ц. Төмөрбаатар (хэвлэлд бэлтгэсэн), сумын 20 жилийн ойд зориулсан, 2014, 263-р тал.

20 Idem, 264-р тал.

21 Idem, 266-р тал.

ХОТ СУУРИЙН ГАЗАР АМЬДАРЧ БУЙ КАЗАХ ИРГЭДИЙН ЭХ ХЭЛНИЙ ХЭРЭГЛЭЭГ СУДАХ ОНЛАЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Судалгаа хийх явцад зарим нэг орон нутгаас үндэстний цөөнх иргэддээ анхаарал хандуулж Наурызын баярын үеэр мэндчилгээ дэвшүүлдэг сайн жишээ байгаа нь харагдаж байна.

Хүснэгт 1.1. Судалгаанд хамрагдсан бүсийн казахуудын тоо²²

№	Газрын нэр	Нийт хүн амын тоо	Казахуудын тоо	Нийт хүн амд эзлэх хувь
1	Улаанбаатар ²³	1 144 954	9 817	0.9%
2	Налайх ²⁴	37 715	3 786	10%
3	Сэлэнгэ аймаг ²⁵	107 755	1015	0.9 %
4	Дархан уул аймаг- Дархан хот ²⁶	102 200	2 612	2.6%
5	Дархан уул аймаг- Шарын гол сум	8 145	1 330	16.3%
6	Орхон аймаг- Эрдэнэт	104 032	673	0.6%
	Нийт	1 504 801	19 233	31.3%

Судалгааны асуумж:

- Хувийн мэдээлэл -7 асуулттай.
- Хэлний өдөр тутмын хэрэглээ -7 асуулттай.
- Хэлний чадвар- 3 асуулттай.
- Хэлний харилцааны орчин- 11 асуулттай.

Нийт 4 үндсэн хэсэг, 28 асуулттай.

Судалгааны асуулгын бүтэц нь хагас бүтэцлэгдсэн буюу зарим асуултын хариултыг өөрөө бичих боломжтой байдлаар ангилсан. Энэхүү задгай асуултууд дээр контент анализ буюу агуулгын шинжилгээ хийлээ.

2.2.1 Хувийн мэдээлэл (1-7-р асуулт)

Хувийн мэдээллийн хэсэг 7 асуулттай, үүнд оролцогчдын нас, хүйс, угсаа, боловсролын түвшин, мэргэжил, оршин суугаа газартай нь холбоотой асуултууд багтаж байна. Судалгаанд оролцогчдийн насны бүлгийг харвал хамгийн залуу нь 9 настай хүүхэд, хамгийн ахмад нь 92 настай хүн оролцжээ. Насны дундаж нь 33 нас байна. Судалгаанд 383 хүн оролцсон бөгөөд 382 хүн өөрийн насыг бичсэн, 1 хүн бичээгүй байна.

22 Хот, суурин газар амьдарч буй Казахуудын нэгтгэсэн тоо хараахан нарийн гараагүй байна.

23 Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын нэгдсэн дүн: Улаанбаатар хот, 51-р тал. 2020 оны тооллогын Улаанбаатар хотын нэгдсэн дүн арай гараагүй бололтой.

24 Тухайн дүүргийн статистикийн ажилтнаас авсан тоо болно.

25 Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын Сэлэнгэ аймгийн нэгдсэн дүн, (Хураангуй), 4-р тал.


26 4, 5, 6-р хүснэгтийн хүн амын тоог тухайн орон нутгийн статистикийн ажилтнаас авсан тоо болно.

Хүснэгт 1.2. Асуулга 1: Оролцогчдын нас.

Дундаж нас	33
Хамгийн залуу	9
Хамгийн ахмад	92


Дээрх асуултад хариулсан 382 хүний 7.9 %-ийг 18 хүртэлх насны, 27 % 19-28 насны, 37,1 %-ийг 29-38 насны, 17.5% нь 39-48 насны хүн эзэлж байгаа бол 49-ээс дээш насны хүмүүс судалгаанд оролцогчдын 10.5% -г эзэлж байна. Үүнээс үзэхэд судалгаанд бүх насныхан жигд оролцжээ гэж үзэж болохоор байна.

Зураг 2.2. Оролцогчдын нас



Хүйсийн бүтцийг харвал нийт судалгаанд оролцогчдын 61.62% нь эмэгтэй, 38.38% нь эрэгтэй байна. Ер нь эмэгтэйчүүд, ээжүүд үр хүүхдийнхээ боловсрол, эх хэлний асуудалд эрчүүдээс илүү их анхаарал хандуулж, эх хэлээ тээдэг гэдгийг судлаачид байнга онцолж бичдэг.


Зураг 2.3. Оролцогчдын хүйс



Боловсролын түвшингээр нь харвал:

- Дээд боловсролтой нь 63.4%
- Мэргэжлийн боловсролтой 12.8%
- Бүрэн дунд боловсролтой 20.6%
- Суурь боловсролтой иргэд 3.2% -г тус тус эзэлж байна.

Зураг 2.4. Оролцогчдын боловсролын түвшин




Судалгаанд оролцогчдын оршин суугаа газрын хувьд

- - 30.3 % буюу 116 хүн Улаанбаатар хотод,
- - 31.3 % буюу 120 хүн Налайх дүүрэгт,
- - 16.2 % буюу 62 хүн Шарын гол суманд


ХОТ СУУРИЙН ГАЗАР АМЬДАРЧ БҮЙ КАЗАХ ИРГЭДИЙН ЭХ ХЭЛНИЙ ХЭРЭГЛЭЭГ СУДЛАХ ОНЛАЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

- 22.2 % буюу 85 хүн Дархан, Эрдэнэт, Сэлэнгэ орчмоор амьдарч байна. Бид анх Улаанбаатар хотоос 100, Налайх дүүргээс 100, Шарын голоос 50, Дархан, Сэлэнгэ, Эрдэнэт орчмоос 50-н, нийтдээ 300 хүнээс асуулга авахаар төлөвлөсөн байсан. Судалгаанд хот, суурин газрын казахууд тун идэвхтэй оролцон 383 хүн хариулсан.

Зураг 2.5. Оролцогчдын оршин суугаа газар



Зураг 2.6. Та энд амьдраад хэдэн жил болж байгаа вэ?




Судалгаанд оролцогсдоос тухайн газраа амьдраад хэр удаж байгааг тандахад талаас илүү буюу 54.8 % -нь 20-оос дээш жил, 16.7% -нь 15-20 жил, 8.6% -нь 10-15 жил амьдарч байгаа бол 10.97% -нь 5-10 жил амьдарч байна. Харин үлдсэн 8.9% -нь тухайн газраа амьдарч 0-5 жил болж байгаа юм байна. Тэгэхээр нийт оролцогчдын 90%-ээс дээш хувь нь тухайн орон нутагтаа 10-аас дээш жил амьдран суурьшсан, 2, 3 дахь үе нь тэнд оршин сууж байгаа нь харагдаж байна. Хотожсон бүсийн албан газар, үйлдвэр, үйлчилгээ, нийгэм соёлын үйл ажиллагаа нь давамгайлах хэл, олонхын хэлний хэрэглээг нэмэгдүүлдэг ба цөөнхийн хэлний хэрэглээ бүүрэх магадлалтай байдаг.

Судалгаанд оролцогчдын ажил мэргэжлийн байдлыг тандахад доорх дүр зураг харагдлаа. Үүнд:

Хүснэгт 1.3. Оролцогчдын ажил мэргэжил

	Ажил мэргэжлийн ангилал	Тоо	Хувь
1	Боловсрол, соёл, шинжлэх ухаан	99	26%
2	Уул уурхай, барилга	69	17.6%
3	Сурагч, оюутан	40	10.3%
4	Эдийн засаг, санхүү	37	10%
5	Эрүүл мэнд	33	8.6%
6	Хууль, эрхзүй	20	5.2%
7	Ажилгүй	19	5%
8	Худалдаа үйлчилгээ	18	4.6%
9	Мэдээллийн технологи	16	4.1%
10	Менежер	12	3%
11	Жолооч	8	2%
12	Олон улсын аялал жуулчлал	8	2%
13	Мал аж ахуйн	4	1%
	Нийт	383	100%

Зураг 2.7. Ажил мэргэжил



Нийт оролцогчдын хамгийн их буюу 26.6% нь Боловсрол, соёл шинжлэх ухааны салбарт ажилладаг багш, нийгмийн ажилтан, орчуулагч, сэтгүүлч нар бол 10.3% нь оюутан, сурагч, 10% нь эдийн засагч, нярав, 8.6% нь эмч, сувилагч гээд нийгмийн бараг бүхий салбарыг хамарсан мэргэжилтэй боловсон хүчин оролцсон бөгөөд ажил мэргэжилгүй хүн нийт оролцогчдын 5%-ийг тус тус эзэлж байна.

2.2.2 Статистик шинжилгээ


Эл хэсэгт хэлний өдөр тутмын хэрэглээ, хэлний чадвар, хэлний харилцааны орчинтой холбогдох тоон үзүүлэлтийг авч үзлээ.

Хэлний хэрэглээг тодруулах энэ хэсэг гурван үндсэн агуулгатай. Эхнийх нь эх хэл (казак) болон төрийн хэл (монгол хэл)-ийг эзэмшсэн байдал, дараагийнх нь эх хэл болон, төрийн хэлийг эзэмшсэн чадвар, нийгмийн харилцаанд эх хэлний гүйцэтгэх үүргийг нь төрийн хэлтэй харьцуулах, харгалзуулах байдлаар тодрууллаа. Сүүлийн хэсэгт нь тухайн оролцогч эх хэлэндээ хандах хандлага, эх хэлээ хадгалах хамгаалах цаашдын зорилтыг нь тодруулахыг зорилоо.

2.2.2.а Хэлний өдөр тутмын хэрэглээ

Судалгаанд оролцсон 383 хүний 79.9% нь л казах хэлийг эх хэлээ гэж үзсэн бол 19,8% нь монгол хэлийг эх хэлээ, 0,3% нь бүсд хэлийг тус тус эх хэлээ гэж үзсэн байна.


Зураг 2.8: Оролцогчдын эх хэл.



Судалгаанд оролцогчдын 79.9% нь казах хэлийг эх хэлээ үздэг хэдий ч яг өдөр тутмын хэрэглээнд эх хэлний хэрэглээ урвуу хамааралтай буюу монгол хэлийг өдөр тутамдаа хэрэглэж, харилцаж буй нь доорх зурган дээр тод харагдана. Хотожсон бүсийн албан газар, үйлдвэр, үйлчилгээ, нийгэм соёлын үйл ажиллагаа нь давамгайлах хэл, олонхын хэлний хэрэглээг нэмэгдүүлдэг ба цөөнхийн хэлний хэрэглээ буурах магадлалтай хэмээснийг энэхүү баримт баталж байна.²⁷


27 Anat Ştavans and Charlotte Hoffmann 2015) Multilingualism, Cambridge, United Kingdom: Cambridge University Press, , Pp 43-46.

Зураг 2.9: Орлогчдын өдөр тутамдаа ямар хэлээр харилцдаг тухайд.




Өдөр тутамдаа Монгол, казах хэлийг хэр хэрэглэдгийг 1-5-ын тоогоор үнэлүүлсэн бөгөөд 1-маш бага, 5- маш их гэх байдлаар авч үзсэн. Монгол хэлийг байнга хэрэглэдэг гэж 266-н хүн буюу 69.5% -нь хариулсан байна. Харин маш бага гэж 2.1% буюу 8 хүн хариулсан байгаа нь судалгаанд оролцсон казах иргэдийн дунд монгол хэлний хэрэглээ маш өндөр байгаа нь харагдаж байна.

Зураг 2.10: Монгол хэлний өдөр тутмын хэрэглээ




Казак хэлийг өдөр тутамдаа дунд зэрэг хэрэглэдэг хэмээн 31.7% буюу 121 хүн үзжээ. Байнга гэж 15.9% -нь хариулсан бол маш бага гэж 20.4% -нь хариулсан байна. Эл хариулт судалгаанд оролцогчид эх хэлээ монгол хэлтэй харьцуулахад маш бага хэрэглэж байгаа бөгөөд зөрөө нь 50% (69.5% - 15.9%) байна.

Зураг 2.11: Казах хэлний өдөр тутмын хэрэглээ



Казах хэлийг хэрхэн сурсан гэсэн асуултанд доорх байдлаар хариулсан. Хариултыг харахад 78.5% нь аав, ээж, 54.1% эмээ, өвөөгөөсөө, 44.4 % нь хамаатан саднаасаа гэсэн нь эх хэлийг сурах орчин нь зөвхөн гэр бүл болсон нь харагдаж байна. 1990-ээд оноос хойш сүм хийдийн үйл ажиллагаа сэргэж, сүсэглэх зан үйл нээлттэй болсон нь эх хэлээ сурах, сэргээх, дадлагажих нэг газар болж нэмэгдсэнийг судалгааны дүн харуулж байна.

Зураг 2.12: Казах хэлийг хэрхэн сурсан тухайд




Судалгаанд оролцогчид анх эх хэлээ хэрхэн сурсан тухайд ийн хариулжээ. 180 гаруй хариулт ирсэн бөгөөд доорх байдлаар ангилж үзэж болохоор байна. 42.3% гэр бүлийн орчинд эмээ, өвөө, хамаатан саднаасаа сурчээ. 9.2% Баян-Өлгий-д төрж өссөн учир, зуны амралтаараа Баян-Өлгийд очсон үедээ гэх мэтээр хариулжээ.

Хүснэгт 1.4. Эх хэлээ анх хэрхэн сурсан

Хүрээ	Ангилал	Давтамж	Хувь
Гэр бүл хэнтэй	Эмээ, өвөө	17	0,4%
	Эцэг, эх	60	15,6%
	Өөр бусад хамаатан	3	0,9%
	Өөрөө	4	1%
Орчин	Гэрийн орчинд	94	24,4%
	Сургууль	11	2%
	Шашин	1	0,2%
	Бусад	1	0,2%
Ондоошил, суурьшил	Хэл, соёлын ялгаатай	28	7,2%
	Газар, нутаг, суурьшилтай	20	5%
Хүний хөгжил	Төрсөн цагаас	26	7%
	Багаас	28	7,2%
Хэлний хэрэглээ чадвар	Өдөр тутам хэрэглэж, харилцаж	9	2,3%
	Сонсож сурсан	5	1,2%
	Сайн мэддэг	8	2%
	Мэдэхгүй / сураагүй	9	2,3%

Сургуулийн өмнөх насанд казах хэлний хэрэглээ өндөр байж байгаад бага ангид орсон үеэс эхлэн эх хэлний хэрэглээ багасаж монгол хэлний хэрэглээ нэмэгдсэн байна. Цаашид дунд, ахлах ангид багассаар монгол хэл болон гадаад хэлний хэрэглээ эрс нэмэгддэг нь доорх зурагнаас тод харагдаж байна.


Зураг 2.13: Өдөр тутмын хэлний хэрэглээ



2.2.2.6. Хэлний чадвар

Хэлний мэдлэгийн чадварыг мэдэхээс өмнө оролцогчийн эх хэлээ мэддэг эсэхийг нь асуухад доорх байдлаар хариулсан юм. Нийт 383 оролцогчийн 82.8% нь эх хэлээ мэддэг, 16.2 % нь мэддэггүй, 1% нь бага зэрэг мэддэг гэж хариулсан.

Зураг 2.14: Эх хэлээ хэрхэн мэддэг



Дараагийн бидний зорилго бол хэлний ялгаатай байдал нь бусад ангилагч хувьсагчүүдаас хамаарсан ямар нэг ялгаа байгаа эсэхийг тодруулахад оршиж буй юм. Юуны түрүүнд судалгаанд оролцогчдын 2 хэлний түвшинд өгч байгаа үнэлгээний тодорхойлогч статистик үзүүлэлтүүдийг харья. Энэ хэсэгт 1 гэсэн оноогоор маш муу, 5-аар маш сайн гэсэн үнэлгээ өгсөн. 5 руу дөхөх тусам тухайн хэлэнд өгч буй өөрийн үнэлгээ нэмэгдэнэ гэсэн үг юм. Судалгаанд оролцогчид Монгол хэлээр ярих чадвараа хамгийн сайн, Казах хэлээр бичих чадвараа хамгийн муу гэж үнэлжээ. Казах хэлний 4-н чадвараас Сонсох чадвараа хамгийн сайн, Монгол хэлний Бичих чадвараа хамгийн муу гэж дүгнэжээ. Казах хэлний бичих чадвараас бусад гурван чадварын голч нь 4 гэсэн утгатай байгаа бол Казах хэлний бичих чадварын голч утга нь 3 байна. Моод буюу хамгийн давтагдсан утга 4 байна. Вариаци буюу хэлбэлзлийг нь харвал Казах хэлний бичих чадварын үнэлгээ хамгийн их хэлбэлзэлтэй байгаа бол хамгийн бага хэлбэлзэлтэй нь Монгол хэлний ярих чадвар байна. Хэлтийлтийн хувьд бүгд хасах утгатай байгаа нь бүх тархалт баруун тийш тархсан болохыг харуулж байна. Хамгийн бага хэлтийлт нь хамгийн ихээр баруун тийш хэлтэйсэн болохыг харуулна.

Хүснэгт 1.5: Оролцогчдын казах, монгол хэлний чадварын статистик

Статистик							
	Утга	Голч утга	Хамгийн их давтагдсан утга	Хазайлт	Хэлбэлзэл	Хэлтийлт	Хэлбийлт
Та монгол хэлний чадвараа үнэлнэ үү? [Сонсох]	4.3708	4.0000	4.00	.64991	.422	-1.236	3.788
Та монгол хэлний чадвараа үнэлнэ үү? [Унших]	4.3734	4.0000	4.00	.66633	.444	-1.502	5.096
Та монгол хэлний чадвараа үнэлнэ үү? [Бичих]	4.3003	4.0000	4.00	.68734	.472	-1.102	2.713
Та монгол хэлний чадвараа үнэлнэ үү? [Ярих]	4.3760	4.0000	4.00	.63051	.398	-.941	2.232
Та казах хэлний чадвараа үнэлнэ үү? [Сонсох]	3.8616	4.0000	4.00	.98372	.968	-1.013	.825
Та казах хэлний чадвараа үнэлнэ үү? [Унших]	3.4386	4.0000	4.00	1.19807	1.435	-.538	-.571
Та казах хэлний чадвараа үнэлнэ үү? [Бичих]	3.0731	3.0000	4.00	1.35364	1.832	-.165	-1.185
Та казах хэлний чадвараа үнэлнэ үү? [Ярих]	3.5614	4.0000	4.00	1.12830	1.273	-.593	-.319

Куртозын хувьд утга нь өндөр байх тусам тархалт нэг газар овойрсон байдал нэмэгддэг, хасах утга нь жигд тарж өгсөн байгааг харуулдаг.

Хосолсон түүврийн тест- Paired sample test

Оролцогчдын хэлний чадвартаа өгч байгаа дээрх үнэлгээг хосмог үүсгээд дунджийн хувьд хоорондоо тэнцүү байгаа эсэхийг шалгая. Ингэж шалгахдаа дараах хосмогууд хоорондоо тэнцүү гэсэн анхдагч таамаглал дээр шалгав.

- Хосмог- Pair1: Монгол хэлний сонсох, Казах хэлний сонсох
- Хосмог- Pair2: Монгол хэлний унших, Казах хэлний унших
- Хосмог- Pair3: Монгол хэлний бичих, Казах хэлний бичих
- Хосмог- Pair4: Монгол хэлний ярих, Казах хэлний ярих

ХОТ СУУРИЙН ГАЗАР АМЬДАРЧ БУЙ КАЗАХ ИРГЭДИЙН ЭХ ХЭЛНИЙ ХЭРЭГЛЭЭГ СУДАХ ОНЛАЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Өөрөөр хэлбэл судалгаанд оролцогчдын Монгол хэлний тухайлсан чадвар Казах хэлний тухайлсан чадвар нь хоорондоо адил түвшинд байгаа эсэхийг шалгаж байгаа хэрэг юм. Хослолуудын хувьд бүгд ач холбогдолтой ($Pvalue < 0.05$) гарсан. Өөрөөр хэлбэл Монгол хэлний тухайлсан чадвар Казах хэлний тухайлсан чадвар нь хоорондоо адил түвшинд байхгүй байна гэсэн үг юм.

Дунджийн ялгааг нь харвал хамгийн өндөр нь Хосмог-Pair3 буюу бичих чадвар ($Pvalue = 0.000$)-ын дунджийн ялгаа нь 1.22725 байгаа нь бусдаасаа хамгийн өндөр байгаа юм. Өөрөөр хэлбэл судалгаанд оролцогчдын Монгол, Казах хэлний бичих чадварын ялгаа хамгийн их байна. Дунджийн зөрүү нь эерэг утгатай байгаа нь Монгол хэлний бичих чадвар нь Казах хэлний бичих чадвараасаа өндөр байгааг харуулж байгаа юм. Энэ нь хот суурийн газар амьдарч буй казахууд Казах хэлээрээ бичиж чадахгүй байна гэсэн үг юм.

Үүний дараа унших чадвар ($Pvalue = 0.000$) буюу хосмог-Pair2-ийг авч үзье. Дунджийн зөрүү нь 0.93473 ба зөрүү нь эерэг утгатай байгаа нь Монгол хэлээр унших чадвар нь Казах хэлээр унших чадвараас өндөр байгааг харуулж байгаа юм. Үүний дараа ярих чадвар ($Pvalue = 0.000$) буюу Pair4 байна. Ярих чадварын зөрүү нь 0.81462 буюу эерэг утгатай байгаа нь Монгол хэлний ярих чадварын үнэлгээ нь Казах хэлний ярих чадварын үнэлгээнээс өндөр байгаа нь мөн харагдаж байна.

Харин хамгийн бага зөрүүтэй нь Сонсох чадвар ($Pvalue = 0.000$) байгаа юм. Дунджийн зөрүү нь 0.50914 байгаа ба эерэг утгатай байгаа нь мөн л Монгол хэлээр сонсох чадварын үнэлгээ нь Казах хэлээр сонсох чадварын үнэлгээнээс дээгүүр байгааг харуулж буй хэрэг юм. Стандарт хазайлтын хувьд Бичих чадварын үнэлгээ хазайлт өндөртэй байгаа бол Сонсох чадварын үнэлгээ хазайлт багатай байгааг доорх хүснэгтээс харж болох юм.

Хүснэгт 1.6: Хэлний чадварын хосолсон түүврийн тест

Хосолсон түүврийн тест - Paired Samples Test									
		Хосмогын ялгаа- Paired Differences					t	df	Sig. (2-tailed)
		дундаж	стандарт Хазайлт	утга	95% ялгааны интервал				
					доод	дээд			
Хосмог 1	12. Та монгол хэлний чадвараа үнэлнэ үү [Сонсох] - 9. Та казах хэлний чадвараа үнэлнэ үү ? [Сонсох]	.50914	1.04571	.05343	.40408	.61420	9.529	382	.000
Хосмог 2	12. Та монгол хэлний чадвараа үнэлнэ үү [Унших] - 9. Та казах хэлний чадвараа үнэлнэ үү ? [Унших]	.93473	1.28968	.06590	.80515	1.06430	14.184	382	.000

ХОТ СУУРИЙН ГАЗАР АМЬДАРЧ БУЙ КАЗАХ ИРГЭДИЙН ЭХ ХЭЛНИЙ ХЭРЭГЛЭЭГ СУДАХ ОНЛАЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Хосмог 3	12. Та монгол хэлний чадвараа үнэлнэ үү [Бичих] - 9. Та казах хэлний чадвараа үнэлнэ үү ? [Бичих]	1.22715	1.49453	.07637	1.07700	1.37731	16.069	382	.000	
Хосмог 4	12. Та монгол хэлний чадвараа үнэлнэ үү [Ярих] - 9. Та казах хэлний чадвараа үнэлнэ үү ? [Ярих]	.81462	1.21276	.06197	.69278	.93646	13.146	382	.000	
Хосолсон түүврийн тест - Paired Samples Test										
		Хосмогын ялгаа- Paired Differences								
		дундаж	стандарт Хазайлт	Std. Error Mean	95% Confidence Interval of the Difference		t	df	Sig. (2-tailed)	
					Lower	Upper				
Хосмог 1	12. Та монгол хэлний чадвараа үнэлнэ үү [Сонсох] - 9. Та казах хэлний чадвараа үнэлнэ үү ? [Сонсох]	.50914	1.04571	.05343	.40408	.61420	9.529	382	.000	
Хосмог 2	12. Та монгол хэлний чадвараа үнэлнэ үү [Унших] - 9. Та казах хэлний чадвараа үнэлнэ үү ? [Унших]	.93473	1.28968	.06590	.80515	1.06430	14.184	382	.000	
Хосмог 3	12. Та монгол хэлний чадвараа үнэлнэ үү [Бичих] - 9. Та казах хэлний чадвараа үнэлнэ үү ? [Бичих]	1.22715	1.49453	.07637	1.07700	1.37731	16.069	382	.000	
Хосмог 4	12. Та монгол хэлний чадвараа үнэлнэ үү [Ярих] - 9. Та казах хэлний чадвараа үнэлнэ үү ? [Ярих]	.81462	1.21276	.06197	.69278	.93646	13.146	382	.000	


Хосмогийн хамаарлын хувьд Монгол хэлээр бичих, Казах хэлээр бичихэд өгч байгаа үнэлгээ хоорондоо хамааралгүй ($Pvalue=0.455$, $r=0.038$) байгаа бол бусад нь хамааралтай байна. Хамаарлын коэффициентүүдийг харвал бүгд эерэг утгатай ба 0.5-с доош коэффициентүүд байгаа нь эерэг сул хамааралтай байна гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл Монгол хэл болон Казах хэлээр бичих чадвар нь хоорондоо хамааралгүй бол бусад нь харилцан бие биентэйгээ эерэг сул хамааралтай байгаа юм.

Хүснэгт 1.7: Хосмогийн хамаарал

Paired Samples Correlations				
		N	хамаарал	Sig.
Хосмог 1	12. Та монгол хэлний чадвараа үнэлнэ үү [Сонсох] & 9. Та казах хэлний чадвараа үнэлнэ үү ? [Сонсох]	383	.232	.000
Хосмог 2	12. Та монгол хэлний чадвараа үнэлнэ үү [Унших] & 9. Та казах хэлний чадвараа үнэлнэ үү ? [Унших]	383	.135	.008
Хосмог 3	12. Та монгол хэлний чадвараа үнэлнэ үү [Бичих] & 9. Та казах хэлний чадвараа үнэлнэ үү ? [Бичих]	383	.038	.455
Хосмог 4	12. Та монгол хэлний чадвараа үнэлнэ үү [Ярих] & 9. Та казах хэлний чадвараа үнэлнэ үү ? [Ярих]	383	.140	.006

Монгол хэлний чадварууд нь Казах хэлний чадваруудаас дунджийн хувьд ялгаатайг шалгаж баталсан билээ. Энэхүү ялгааны зөрүүг дараах графикт харууллаа. Энд Монгол хэлний чадвар нь Казах хэлний чадвараас хэр их зөрүүтэй байгааг харуулж буй бөгөөд бичих чадвар нь хамгийн их зөрүүтэй байгаа нь харагдаж байна.

Зураг 2.15: Хэлний чадварын ялгаа



2.2.2.в. Харилцааны орчин буюу хэлний сонголт

Хэлний чадварыг судалсаны дараа оролцогчдын хэлний харилцааны орчинг сонирхон судалсан билээ. Хэл шинжээч Фишман (Fishman.1972) хэлийг нийгэм талаас судлахдаа “Хэлний хэрэглээний хүрээ”²⁸ хэмээх ойлголтыг анх гаргасан бөгөөд энэхүү ойлголтод хэлийг сонгоход нөлөөлж буй хаана, хэн, хэнтэй, ямар сэдвээр ярих буюу хэлний сонголт авч үзэх хэрэгтэй гэжээ. Тиймээс энэхүү судалгаанд үүнийг баримтлалаа.

28 Language Science Monographs, Fishman, Joshua A. Indiana University Publications Vol. 7, Bilingualism in the Barrio. Bloomington: Indiana University, 1971. 34 тал


Асуулт: Та дараах хүмүүстэй ямар хэлээр харилцдаг вэ?

Хүснэгт 1.8: Аль хэлээр харилцдаг тухай

	Аав	Ээж	Төрсөн ах/ Эгч	Өвөө/ Эмээ	Төрөл садан	Анги, хамт олон	Найз нөхөд	Хөрш	Багш	Бусад хүмүүс
Казах	35.2	34.2	18.8	45.2	20.4	4.7	2.6	2.9	1.8	1.6
Ихэвчлэн Казах	9.9	11.2	11.7	18.0	17.5	2.1	2.1	2.6	1.3	2.1
Казах ба Монгол	38.4	39.4	38.4	26.1	44.6	15.7	34.5	25.1	11.5	23.2
Монгол	12.0	11.2	23.2	6.8	12.0	65.8	49.9	58.2	72.3	59.0
Ихэвчлэн Монгол	3.1	3.7	7.8	3.1	5.5	11.2	10.4	10.2	12.0	12.0
Гадаад хэл	.3					.3	.5	.8	1.0	.8
Бусад	1.0	.3		.8		.3		.3		1.3
Нийт	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0


Дээрх 1.8 хүснэгтээс харвал оролцогч өвөө эмээ, аав, ээжтэйгээ Казах хэлээр ярих нь их байна. Ер нь гэр бүлийн хүрээнд буюу аавтайгаа 39.4%, ээжтэйгээ 38.4%, төрсөн ах, эгчтэйгээ 38.4%, төрөл садантайгаа 44.6% нь, мөн найз нөхөдтэйгээ 34.5% нь Казах болон Монгол хэлээр харьцдаг бол анги хамт олон, хөрш, багштайгаа Монгол хэлээр түлхүү харьцаж байна. Нийгмийн хүрээнд авч үзвэл Казах, Монгол хэлийг холимог байдлаар найз нөхдийн хүрээнд их хэрэглэж буй нь харагдаж байна. Хүснэгтээс харвал Монгол хэлний хэрэглээ баруун тийш болох тусам хэрэглэх хувь нь өсч байгаа нь гэр бүлийн харилцаанаас нийгмийн харилцаа руу шилжих тусам Монгол хэлний хэрэглээ нэмэгдэж байна гэсэн үг юм. Казах хэлийг ойр тойрны гэр бүлийн хүрээнд л түлхүү хэрэглэж байгаа бол дан Казах хэлээр эцэг эх, өвөө эмээгийн хүрээнд л их байгааг харж болох юм.

Зураг 2.16: Аль хэлээр харилцдаг тухай /хувиар/



Оролцогч зөвхөн гэртээ л казах хэл, заримдаа казах, монгол хэлийг хольж хэрэглэх боломжтой болохоос сургууль, анги, танхим, дэлгүүр, худалдааны төв, банк, лавлах үйлчилгээнд зөвхөн монгол хэлийг ашиглаж буй нь харагдаж байна. Тэгэхээр судалгаанд оролцогчийн казах хэлний орчин нь зөвхөн гэр бүлийн хүрээнд гэдэг нь батлагдаж байна.

Зураг 2.17: Та дараах хэлийг ямар орчинд илүү хэрэглэдэг вэ?



Асуулт. Та дараах нөхцөлд ямар хэлийг хэрэглэдэг вэ?

Хүснэгт 1.9: Оролцогсад доорх нөхцөлд аль хэлийг түлхүү ашигладаг тухай


	Зөвхөн Казах	Ихэвчлэн Казах	Зөвхөн Монгол	Ихэвчлэн Монгол	Бусад хэл	Гадаад хэл
Ном унших	1.3	7.0	47.8	35.5	3.4	3.9
И-Мэйл бичих	.8	2.3	54.8	28.7	3.9	8.1
Мессэж бичих	.8	8.4	44.6	39.4	2.6	3.1
Нийгмийн сүлжээ	.5	3.1	52.5	37.3	2.3	3.1
Сургуулийн цахим хуудас	.5	.8	57.4	37.1	.5	1.8
Тэмдэглэл хөтлөх	2.9	5.2	52.5	34.5	1.0	2.1
Зурагт үзэх	1.3	5.2	47.5	37.1	2.3	5.2
Хөгжим сонсох	4.4	21.7	31.1	22.2	8.9	10.2
Кино үзэх	2.3	7.3	41.3	32.6	6.5	7.8
Интернэт орчин	1.6	4.4	45.4	32.6	6.8	8.1
Сүсэглэх	38.4	23.2	19.8	10.7	1.8	1.3

Өдөр тутмын хэрэглээнд зөвхөн Монгол хэл бүх хэрэглээнд өндөр байгаа ч сүсэглэх үед өндөр биш байна. Сүсэглэх үед Зөвхөн Казах болон Ихэвчлэн Казах хэлийг ашиглах байдал их байна. Энэ нь Казах үндэстний шашны номлол, зан үйл тухайн хэл дээр түлхүү явдагтай холбоотой гэж үзэж байна. Хотожсон бүсийн хэл нь зарим нэг онцлогийг хадгалсан түүхэн хэл байж болно. Тухайлбал, хотын тодорхой бүсэд тухайн үндэстэн өөрсдийн үйлдвэрийг барих, суурьших, шашны зорилгоор тогтмол цугларах зэрэг нь хэл соёлоо хадгалан хамгаалах нөхцөл болдог.²⁹

Бүхэл байдлаар нь дүгнээд үзвэл өдөр тутмын нөхцөлд ихэнхдээ Монгол хэлийг ашиглаж байгааг харж болох юм. Хүснэгт 2.9-ээс ном товхимол, нийгмийн сүлжээ, кино, хөгжим, интернэт орчин гэх зүйлийг монгол хэлээр түлхүү хэрэглэдэг нь харагдаж буй бөгөөд казах хэлээр эдгээр хэрэглээ хомс, хангалтгүй байгааг давхар харуулж буй юм. Бусад хэл болон гадаад хэлний хэрэглээ нь хөгжим сонсох, кино үзэх, интернэт орчин, мэйл бичих мэт орчин үеийн нийгмийн нөхцөл шаардлагатай уялдан ашиглагдаж байна. Эдгээрийг графикт тусгаж харуулвал дараах байдалтай байна. 1990-ээд оноос хойш шашин шүтэх, сүсэглэх эрх чөлөөтэй болсноос хойш Казахууд төвлөрөн сууж буй газруудад ислам шашны мешит- сүм хийдийг барьж байгуулж байна. Эдгээр сүм хийдэд очиж сүсэглэх үед эх хэлээ сэргээх, ядахдаа ярих, унших чадвараа сайжруулах боломж бүрдэж байгаа нь сайн хэрэг юм.


29 Anat Ştavans and Charlotte Hoffmann 2015) Multilingualism, Cambridge, United Kingdom: Cambridge University Press, , Pp 43-46.

Зураг 2.18: Аль нөхцөлд ямар хэлийг хэрэглэдэг вэ? /хувиар/



Хэлний хэрэглээг тогтоосны дараа оролцогчид өөрсдийгөө хос хэлтэн үү, үгүй гэж үздэгийг нь нь тодруулсан юм.

Зураг 2.19: Ямар нөхцөлд хос хэлээр харилцдаг тухай




Судалгаанд оролцогсдоос Ямар нөхцөлд хос хэл хэрэглэдэг талаар асуухад эцэг, эх, гэр бүлтэйгээ “заримдаа” гэж хариулсан нь хамгийн их байгаа юм. Харин байнга гэж

ХОТ СУУРИЙН ГАЗАР АМЬДАРЧ БУЙ КАЗАХ ИРГЭДИЙН ЭХ ХЭЛНИЙ ХЭРЭГЛЭЭГ СУДЛАХ ОНЛАЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

8.1% бол огт үгүй гэж 12.3% -нь хариулсан байна. Найз нөхөдтэйгээ 38.9% нь казах, монгол хэлийг хольж хэрэглэж байна. Харин байнга гэж 8.1% буюу 31, Огт үгүй гэж 24% -нь хариулсан байгаа юм. Нийгмийн сүлжээнд хос хэлийг огт хэрэглэдэггүй гэж 143 хүн буюу 37.3% нь хариулжээ. Харин байнга гэж 8.1% хариулсан бол заримдаа гэж 27.2% хариулсан байна.


Бид дараа нь аль насандаа ямар хэл хэрэглэж байсныг тандахад: 1-3 насандаа ямар хэлийг голлон хэрэглэж байсан талаар асуухад 41% -нь зөвхөн Казах хэл, 4.7% -нь Ихэвчлэн Казах хэл хэрэглэж байсан бол 34.2% -нь Казах ба Монгол хэлийг холимог хэрэглэж байсан байна.

Зураг 2.20: 1-3 насанд аль хэлийг голлон хэрэглэж байсан тухай.



Харин 3-5 насандаа 32.6% -нь Зөвхөн Казах хэл хэрэглэж байсан бол 6% -нь Ихэвчлэн Казах хэл хэрэглэж, 38.9% -нь Казах, Монгол хэл холимог байдлаар хэрэглэж байсан байна.


Зураг 2.21: 3-5 насанд аль хэлийг голлон хэрэглэж байсан тухай.



ХОТ СУУРИЙН ГАЗАР АМЬДАРЧ БУЙ КАЗАХ ИРГЭДИЙН ЭХ ХЭЛНИЙ ХЭРЭГЛЭЭГ СУДЛАХ ОНЛАЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН


Бага ангидаа Казах ба Монгол хэлийг 35.8% -нь хэрэглэж байсан бол зөвхөн Казах хэл 17.5% -нь хэрэглэж байжээ. Гадаад хэл болон бусад хэлийг 1, 2 хүн л хэрэглэж байсан байна. Харин Зөвхөн Монгол хэлийг 22.7% -нь хэрэглэж байсан байна.

Зураг 2.21: Бага ангидаа аль хэлийг голлон хэрэглэж байсан тухай.




Дунд ангид Казах ба Монгол хэлийг түлхүү хэрэглэж байсан бол Зөвхөн Казах хэл гэж 9.9% хэрэглэж байсан нь харагдаж байна. Зөвхөн Монгол хэл хэрэглэж байсан гэж 25.8% -нь хариулсан байна.

Зураг 2.21: Дунд ангидаа аль хэлийг голлон хэрэглэж байсан тухай.




Ахлах ангидаа хэрэглэж байсан хэлийг нь харж үзвэл Зөвхөн Казах хэл гэж 6.5% -нь хариулсан бол Казах ба Монгол гэж 35.5% -нь хариулсан байна. Харин Зөвхөн Монгол гэж 27.2% -нь хариулсан байна.

Зураг 2.22: Ахлах ангидаа аль хэлийг голлон хэрэглэж байсан тухай.




Бидний дараагийн асуулга бол оролцогчдын эх хэлний сонирхол хэр байгааг тандан судлах явдал байв. Та Казак хэл сурахыг хүсдэг үү? гэж асуухад 344 –нь буюу 89.8% –нь Тийм гэж хариулсан бол 39 буюу 10.2% –нь Үгүй гэж хариулсан байна.

Зураг 2.23: Казак хэл сурахыг хүсдэг үү?




Эх хэлээ мэддэггүйдээ санаа зовнидог үү? гэж асуухад 307 –нь буюу 81.9% –нь тийм гэж хариулсан бол 76 –нь буюу 18.1% үгүй гэж хариулсан байна.

Зураг 2.24: Эх хэл мэддэггүйдээ санаа зовнидог үү?




Танай орон нутагт Казах хэлний дугуйлан, секц байдаг үү? гэж асуухад 19 –нь тийм гэж хариулсан, 273 –нь үгүй гэж хариулсан, 91 –нь сайн мэдэхгүй байна гэж хариулсан.

Зураг 2.25: Казах хэлний дугуйлан, секц байдаг тухайд.



Та өөрийгөө хос хэлтэн гэж үздэг үү? гэхэд 340 –нь тийм гэж хариулсан бол 34 –нь үгүй гэж хариулсан. 9 –нь хариулахаас татгалзсан байна. Судалгаанд оролцогчдын 90.9% нь буюу олонхи нь өөрийгөө хос хэлтэн гэж тодорхойлжээ.

Зураг 2.26: Оролцогч өөрийгөө хос хэлтэн гэж үздэг тухайд.



Эцэст нь эх хэлээ сурч мэдэхэд юу хийх хэрэгтэй саналыг нь асуухад доорх байдлаар хариулсан байна. Оролцогчдын ихэнхи хувь нь сургалтын хөтөлбөрт эх хэлний хичээл тусгах, дугуйлан дамжаа зохион байгуулах, орчин бүрдүүлэх, ном сурах бичгээр хангах асуудлыг хөнджээ.

Хүснэгт 1.10: Эх хэлээ суралцахад хэрэгтэй зүйлс

	Агуулга	Давтамж	Хувь
Боловсрол	Албан боловсролд хичээл, хөтөлбөрт тусгах	63	19,3%
	Мэргэжлийн багш бэлтгэх, хангах	10	3%
	Ном сурах бичиг	28	8,5%
	Сургууль, цэцэрлэг байгуулах	5	1,5%
	Дугуйлан, дамжаа, сургалт зохион байгуулах	74	22,6%
Орчин	Эцэг эхийн дэмжлэг	42	13%
	Казах хэлийг дэмжсэн орчин бүрдүүлэх	39	12%
Мэдээллийн хэрэгсэл	Казах хэлтэй суваг, хичээл, сонирхолтой танин мэдэхүйн нэвтрүүлгийг нэмэгдүүлэх	30	9%
Хэлний эрх	Эх хэлээр боловсрол эзэмших, Хэл, соёлоо өвлүүлэх	24	7,3%
	Сурах хүсэл, эрмэлзэл	15	4,6%
Бодлого	Төр засгийн бодлогоор дэмжих	5	1,5%
	Мэдэхгүй	12	3,6%
	Хариулаагүй	45	11,7%

Судалгааны хамгийн сүүлд хос хэлний талаар хэлэх саналаа бичихийг хүссэн билээ. Нийт оролцогчдын 169 нь доорх саналыг өгсөн бөгөөд 98 нь санал байхгүй, 116 нь хариулаагүй байв. Санал өгсөн хүмүүс хос хэлтэй байхыг дэмжих, төв, суурин газар амьдарч буй казахуудын эх хэлний асуудлыг бодлогоор дэмжих, хадгалан хамгаалах, хэрэглээг дэмжих, нэвтрүүлэг бэлтгэх, орчин бүрдүүлэх зэргийг дурьджээ.

Хүснэгт 1.11: Хос хэлний талаархи санал хүсэлт

	Агуулга	Давтамж	Хувь
1	Хос хэлтэй байхын давуу талыг дэмжсэн	72	42,6%
2	Эх хэлээр сурч боловсрох асуудлыг хөндсөн, хэлний эрх	30	17,7%
3	Төв суурин газар казах хэлийг бодлогоор дэмжих санал оруулах	27	16%
4	Эх хэл соёлоо хадгалан хамгаалах, өвлүүлэх, хэрэглээг дэмжих	16	9,5%
5	Эх хэлээ сурах хүсэл эрмэлзэл- сайн сураагүйд эмзэглэж буй	10	6%
6	Хоёр хэлийг холин хэрэглэх, хэлний чадвар тэнцвэргүй	5	2%
7	Нэвтрүүлэг бэлтгэх	6	2,5%
8	Хос хэлний орчин бүрдүүлэх	10	6%
9	Судалгааны талаар	2	1%
10	Санал байхгүй хэмээн хариулсан	98	
11	Санал бичээгүй	107	

2.3. ДҮГНЭЛТ

Судалгаанд 383 хүний хариултыг ашигласан бөгөөд бүх насны хүмүүс тэгш хамрагдсан.

Хүйсийн хувьд эмэгтэйчүүд түлхүү хамрагдсан бөгөөд дээд боловсролтой хүмүүс нийт оролцогчдын 63.4%-ийг эзэлж байна. Оршин суугаа байршлын хувьд өгөгдсөн байршлууд дээр жигд байна. Харин оршин байгаа газрын хувьд талаас илүү хувь нь 20-оос дээш жил амьдарч байгаа иргэд байна.

Монгол, Казах хэлний 4 чадварыг нь харьцуулж үзэхэд хэлний чадвартаа өгч байгаа үнэлгээ бүгд хоорондоо ялгаатай гарлаа. Монгол хэлний чадвартаа өгч байгаа үнэлгээ Казах хэлнийхээ тухайн чадварт өгч байгаа үнэлгээнээс илүү байна. Энэ нь Монгол хэлэнд өгч байгаа үнэлгээ нь өндөр, Казах хэлний чадварт өгч байгаа үнэлгээ бага байна гэсэн үг юм. Хэлний чадвараас хамгийн их ялгаа бичих чадвар дээр харагдаж байна. Сонсох чадварын хувьд ялгаатай байгаа хэдий ч бусад чадвартай нь харьцуулахад харьцангуй бага байгаа юм.

Гэр бүлийн хэрэглээнд Казах болон казак-монгол хэлний холимог хэрэглээ өндөр байна. Харин гэр бүлээс гадуурх (нийгмийн харилцаанд) хэрэглээнд Монгол хэлний хэрэглээ өндөр байна. Гэртээ илүүтэй Казах хэлийг хэрэглэж байгаа бол нийгмийн бусад орчинд ихэвчлэн Монгол хэлийг хэрэглэж байна. Өдөр тутмын хэрэглээнд аль хэлийг хэрэглэж байгааг харвал Сүсэглэх үед зөвхөн казах хэлийг хэрэглэх хэрэглээ өндөр байгаа бол бусад тохиолдолд монгол хэл түлхүү байна. Харин хөгжим сонсох, кино үзэх гэх мэт дээр гадаад хэл болон бусад хэлний хэрэглээ өндөр байна.

Судалгаанд оролцогчид бага насандаа казак хэлийг түлхүү хэрэглэж байгаад нас ахих тусам казах ба монгол хэлийг хольж хэрэглэж, ахлах ангид ороод эхлэх үед казах хэлнийх нь хэрэглээ буурч байгааг судалгааны үр дүн харуулж байна.

Судалгаанд оролцогчид өөрсдийгөө хос хэлтэн гэж үздэг ч эх хэлээ хангалттай сайн мэдэхгүй байгаадаа санаа зовнидог гэж хариулсан байна. Мөн казах хэл сурахыг хүсдэг ч тухайн орон нутагт нь Казах сургууль, казак хэлний сургалтын төв байхгүй байна.

Хот, суурин газар амьдарч буй казахууд эх хэлний асуудалд маш их санаа зовж байгаа нь судалгаанаас харагдаж байна. Тэд зөвхөн гэр бүлийн хүрээнд болон сүсэглэх үедээ л эх хэлээ ашиглах боломжтой нь байгаа нь казах иргэдийн эх хэлээ сурах, суралцах эрх нь зөрчигдөж байна гэж үзэж байна. Соёлын тухай хуулийн тавдугаар зүйлд “Эх хэл, бичиг үсэг сурах, өвлөх, өвлүүлэх, хөгжүүлэх, элдэв халдлагаас сэрэмжлэн хамгаалах” талаар, Бага, дунд боловсролын тухай хуульд “эх хэлээрээ зөв ярьж, бодол санаагаа ойлгомжтой илэрхийлэх, уншиж бичих, эх хэлээрээ утга төгөлдөр найруулж бичих, ярих чадвар эзэмшүүлэх” талаар тус тус заасан. Мөн Боловсролын тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр “Үндэстний цөөнхийн боловсрол эзэмших, зан заншлаа өвлөх, сургуулийн орчинд төрөлх хэлээрээ харилцах нөхцөлийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах”-ыг баталгаажуулан өгсөн. Үндэстний цөөнхийн эх хэлээрээ сурч боловсрох эрхийг баталгаажуулсан хууль тогтоомжийн эдгээр заалтуудаас харахад үндэстний

цөөнхийн хүүхдүүд нь эх хэлээрээ сурч боловсрох, харилцах, соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах эрхтэй гэдгийг олон хуулийн заалт, хүний эрхийн пактаас харагддаг.

Эх хэлээ сурч боловсрох эрхээ хот, суурин газар амьдарч буй казахууд эдэлж чадахгүй байгаа нь судалгааны дүнгээс харагдаж байна. Хот, суурин газар амьдарч буй казахууд залуу үедээ эх хэлээ өвлүүлэх, сургах тал дээр санаа тавьж, зовинож санал, санаачлага гаргадаг хэдий ч төрийн нэгдсэн бодлого үгүй тул удаан үргэлжилдэггүй байна. Шарын гол суманд 1993-1994 оны хичээлийн жилд Казах бага сургууль нээж нэг удаа төгсөлт хийсэн боловч багшлах боловсон хүчин дутмаг, ном сурах бичиг хангалтгүй байсан зэргээс болж хаагдсан байна. Улаанбаатар хотод гэхэд “Анашуагы” Хүүхэд харах үйлчилгээний төв 2016 онд байгуулагдан 15 хүүхэд хүлээн авах зөвшөөрөлтэй хэдий ч бүртгэлийн үеэр 60-80 хүүхэд бүртгүүлдэг байна. 2018-2020 онд “Ел Бирлиги” ТББ Налайх дүүргийн алслагдмал газар амьдардаг, амьжиргааны түвшин доогуур өрхийн 30 хүүхдийг дотуур байранд байрлуулан казах хэлний анхан шатны сургалт явуулж иржээ. Иргэдийн зүгээс ийм сайхан оролдлого, хичээл зүтгэл байгаа хэдий ч төрийн бодлого байхгүй тул удаан үргэлжилдэггүй, хийж буй ажлыг нь ойлгохгүй хардах сэрдэх, дэмжихгүй байх зэрэг хандлага гардаг тухай асуулгад оролцсон иргэд ярьж байв.

Хот, суурин газар казахууд амьдраад 100-аад жил болох гэж байхад өнөөдөр тэдний хэл, соёлыг дэмжсэн бодлогын баримт бичиг, соёлын төв, номын худалдаа, үзвэр үйлчилгээ гэх зүйл үнэндээ юу ч алга байна. Хэдийгээр ислам шашны сүм, хийд баригдаж сүсэглэх эрч чөлөөтэй болсон хэдий ч эх хэлийг нь БСШЯ-ны харьяа байгууллага хариуцан, үндэстний цөөнх иргэдийн эх хэлний асуудлыг Төрийн бодлогын хэмжээнд авч үзэх ёстой юм.

ХОС ХЭЛНИЙ СУРГАЛТЫН НЭГ ЭЛЕМЕНТ БОЛОХ СОЁЛЫН МЭДЛЭГТ АНХААРАХ ЭРЭЛТ ХЭРЭГЦЭЭ¹

Түлхүүр үгс: соёл хоорондын боловсрол, соёлын мэдлэг, сургалтын хөтөлбөр, харилцан ойлголцол, хүлцэн тэвчил, нийгмийн эв эе.

Оршил (судалгааны үндэслэл, хэрэгцээ, шаардлага, дэвшүүлж буй асуудал)

1992 оны Монгол Улсын Үндсэн хууль дахь “үндэстний цөөнх”, “үндэс”, “угсаа” зэрэг нэр томъёо нь улс төр, нийгэм, эдийн засаг, соёлын хүрээний өөрчлөлт, олон улсын гэрээний нэр томъёотой уялдан шинэ утга агуулга бүхий болсон ажээ.

Монгол улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоос хэвлүүлсэн “Хүний эрхийн товч тайлбар”-т “Үндэстний цөөнхийн эрх (National minority rights)” хэмээх нэр томъёог “Угсаатан, шашны ба хэлний цөөнх оршдог орнуудад эдгээр цөөнхөд багтдаг хүмүүст тухайн цөөнхийн бусад гишүүний хамтаар өөрийн соёлыг эзэмших, шашнаа шүтэх, ёслолоо үйлдэх, түүнчлэн эх хэлээрээ ярих эрхийг хорьж болохгүй. (Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 27 дугаар зүйл) гээд “Үндэстний цөөнх гэдэг нь тухайн улсын хүн амын дийлэнхтэй харьцуулахад тооны хувьд цөөнх болох хэл, арьсны өнгө, соёл иргэншлийнхээ хувьд ялгарах өөрсдийн өвөрмөц байдлыг хадгалах хүсэл эрмэлзэл бүхий тодорхой бүлэг хүмүүсийг хэлнэ.” гэжээ. Монгол улсад үндэстний цөөнхийн 2 том төлөөлөл оршин амьдардаг ба казах, тува (цаатан) үндэстнүүд өөрийн хэл, соёл, зан заншил, шашин шүтлэг, угсаатны цөөнхөө өнөөдрийг хүртэл хадгалж ирсэн байна” хэмээн тодорхойлжээ.

2006 онд Нээлттэй нийгэм форум, НҮБХХ-ийн хамтарсан санхүүжилтээр хэвлүүлсэн “Ардчилсан засаглал, нээлттэй нийгмийн нэр томъёоны тайлбар толь”-д “Үндэстэн хэмээх нэр томъёо нь хос утгыг агуулна. Нэгд, хуучинсаг утгаараа тогтвортой байдлыг, өөрөөр хэлбэл аль нэгэн үндэс язгуур нэгтэй угсаатны бүлэгт хамааралтай байхыг хэлнэ. Энэхүү үндэстэн гэдэг нь тодорхой төрлийн нэгдмэл шинж тэмдгүүдийг (нэг хэл яриа, соёл, түүх) өөртөө агуулсан, нэг нутаг дэвсгэр дээр оршин суух отог омгийн нийгэмлэг юм. Хоёрт, илүү нээлттэй байдлаар тайлбарлавал үндэстэн гэдэг нь хувьсан өөрчлөгдөх, хөгжин дэвших боломжийг нэрийднэ. Энэхүү боломж нь нэг улс хэмээх том бүлгийн дотор хамтран амьдарч, хоорондоо ижил төстэй болон тэс өөр шинж тэмдгүүдийг агуулсан, иймээс ч янз бүрийн яс үндэс, угсаа гаралтай хүмүүсийн тэрхүү соёл нь хоорондоо холилдож, өөрчлөгдөн хөгжих боломж

1 “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвслийн ерөнхий зохицуулагч Д.Тунгалагийн судалгааны ажлын өгүүлэл бөгөөд “Монгол дахь үндэстний цөөнхийн хүүхдийн хос хэлний сургалтын өнөөгийн байдал, чиг хандлага” эрдэм шинжилгээний анхдугаар хурлын эмхэтгэлд анх нийтлэгдсэн болно.

болдог. Өөрөөр хэлбэл, угсаа язгуурын бус, харин харилцан хамааралтай байх сэтгэлгээтэй бүлэг хүмүүсийг үндэстэн хэмээн нэрийднэ. Энэхүү нээлттэй байдлыг илтгэх тайлбар нь өнөөгийн ардчилсан нийгмийн тухай ойлголтод илүүтэй нийцнэ.

Боловсролын хуулиар боловсрол, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бүх шатны боловсролын сургалтын байгууллагын сургалтын агуулга, хөтөлбөр, сургалтын төлөвлөгөөг батлах, түүнчлэн суралцагчдын дийлэнх олонх хүн амын өөр хэл бүхий үндэстний цөөнх байвал сургалтыг хос хэлний хөтөлбөрөөр явуулах бөгөөд хос хэлний хөтөлбөрийн агуулгыг батлах үүрэг хүлээжээ. Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн нутаг дэвсгэртээ үндэсний цөөнхийн боловсрол эзэмших, соёл, зан заншлаа өвлөх, сургуулийн орчинд төрөлх хэлээрээ харилцах нөхцөлийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах бүрэн эрхтэй байхаар хуульчилсан нь 2 талтай.

1996 онд батлагдсан Соёлын тухай хуульд соёлын үйл ажиллагаа явуулахад төрийн болон бусад байгууллага, улс төрийн нам, эвсэл, холбоо, тэдгээрийн албан тушаалтан хөндлөнгөөс оролцох, дарамт шахалт үзүүлэх, угсаатан ястны соёлыг ялгаварлан гадуурхах, хавчин хязгаарлах, дайн түрэмгийлэл, хүчирхийлэл, садар самууныг сурталчлах, Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, соёлд хор хохирол учруулах соёлын үйл ажиллагаа явуулахыг хориглох заалт оруулсан нь тун чухал ач холбогдолтой юм.

Боловсролын тухай хуулиар боловсролын агуулга нь суралцагчийн хувийн болон нийгмийн хэрэгцээ, үндэсний өв, шинжлэх ухаан, технологийн хөгжлийн хандлагад нийцүүлэн боловсролын зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэнэ. Тухайн шатны боловсролын агуулгыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хөтөлбөрөөр зохион байгуулна. Бүх сургууль бага, суурь, бүрэн дунд боловсролын цөм хөтөлбөрийг дагаж мөрдөхөөр хуульчилсан.

Бүх шатны боловсролын хөтөлбөрт монголын түүх, хэл, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч сэтгэлгээ, хувь хүний төлөвшил, хөгжил, гэр бүл, хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйл, суралцагчийн гүйцэтгэх сайн дурын үйл ажиллагааны төрөл, агуулгыг заавал тусгаж, музей, номын сан, кино зэрэг соёл, урлаг, спортын байгууллагын боломжийг ашиглахаар зохион байгуулахаар хуульчилсан байна.

Бага дунд боловсролын тухай хуулиар Суурь боловсролын агуулга нь гоо зүй, ёс суртахууны соёлтой, эрүүл чийрэг, иргэний үүргээ ухамсарласан, үнэнч шударга, хамтач, энэрэнгүй, эх оронч, хууль ёсыг дээдлэн сахидаг, үндэсний болон хүн төрөлхтний дэвшилт ёс заншил, соёлын үнэт зүйлсийг хүндлэн хайрладаг болгон төлөвшүүлэх зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэж байна.

“Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвслээс ХЭҮК-той хамтран Монгол улсын 3 үндэстний бүлэг хамтран амьдардаг Баян-өлгий аймагт хүүхдийн сурч боловсрох эрх хэрэгжиж байгаа нөхцөл байдлын үнэлгээ хийсэн билээ. Тус аймагт нэг талаас хэл, соёл, зан заншлын өвөрмөц ялгаа бүхий казах болон тува үндэстнүүд амьдрах бөгөөд нөгөө талаасаа энэхүү өвөрмөц соёлын дунд хэлний цөөнх болон амьдарч буй халх, дөрвөд, урианхай, тува зэрэг халх угсаатнууд зэрэгцэн оршсон өвөрмөц онцлогтой.

Монгол Улсад амьдарч буй үндэстний цөөнхүүд төвлөрөн амьдардаг гэдэг утгаар нь өнгөрсөн жилүүдэд Баян-Өлгий аймагт суралцаж буй казах хүүхдүүдийн сурч боловсрох эрх, боловсролын чанарыг хөндөн судалсан судалгаанууд байдаг боловч олон үндэстэн угсаатны хүүхдүүдийн хамтдаа сурч боловсрох эрхийн хэрэгжилт, боловсролд тулгамдаж буй асуудлыг нээн илрүүлсэн судалгаа одоогоор хийгдээгүй байна.

Соёл хоорондын харилцан ойлголцол, боловсролын асуудал боловсролын судлаачдын дунд нэлээд хугацаанд хэлэлцэгдэж, судлагдаж ирсэн байдаг. Өөрөөсөө өөр соёлтой хүмүүст нээлттэй байх, тэднийг сонирхох, тэдний тухай олж мэдэхийг хүсэх, өөрийгөө тэдний оронд тавьж үзэх, энэхүү ондоо байдлын тухай мэдлэгээ бусадтай харьцахдаа хэрэглэх, нийтлэг зорилгын төлөө хамтран ажиллахад чиглэсэн соёл хоорондын үзлийг суулгах эрэлт хэрэгцээ боловсролын салбарт нэгэнт үүссэн байна.

Судалгааны зорилго, зорилт

Баян-Өлгий аймагт амьдарч байгаа угсаа гарал, хэл, соёлын хувьд ялгаатай, хэлний цөөнх болох халх, дөрвөд, урианхай, тува, казах угсаатны бүлгийн хүүхдүүдийн сурч боловсрох эрх, төрөлх хэлээрээ сурч боловсрох эрхийн хэрэгжилтэд нөхцөл байдлын үнэлгээ хийж, цаашид авах арга хэмжээг тодорхойлон, санал зөвлөмж боловсруулах зорилгоор энэхүү судалгааг хийж гүйцэтгэсэн.

Хэлний цөөнх хүүхдийн сурч боловсрох эрхийн хэрэгжилтэд нөхцөл байдлын үнэлгээ хийхдээ НҮБ-ын Хүний эрхийн комиссын тусгай илтгэгч Катерина Томашевскийн (1999) боловсруулсан 4А-ийн аргачлал буюу сурч боловсрох эрхийн Хүртээмж, Хүрэлцээ, Хүлээн зөвшөөрөгдөх байдал, Цаг үетэйгээ зохицсон байх гэсэн ойлголтыг судалгааны хүрээ болгон авч ашиглалаа. Төр хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгааг харах зорилготой 4А-ийн аргачлал² нь дэлхийн олон оронд хүүхдийн сурч боловсрох эрхийн хэрэгжилтийг үнэлэх, тодорхойлоход өргөнөөр хэрэглэгдэж байна.

Судалгааны арга зүй

Баян-Өлгий аймаг засаг захиргааны 14 нэгжтэй, үүнээс 11 нэгжид хэлний цөөнх хүүхдүүд амьдарч, сурч боловсорч байгаа ба үлдсэн сумдуудын хүн амын угсаатны бүтцийг казах угсаатан дангаараа бүрдүүлэн амьдардаг тул түүвэрт оруулаагүй болно. Судалгааны мэдээллийг 2016 оны 12 дугаар сарын 16-26 хооронд Баян-Өлгий аймгийн 4 сум, 1 баг, аймгийн төвийн 2 сургууль буюу нийт 7 сургуулиас цуглуулсан.

2 K. Tomaševski, Right to education primers no. 3; Human rights obligations: Making education available, accessible, acceptable and adaptable. pages 12-14

ХОС ХЭЛНИЙ СУРГАЛТЫН НЭГ ЭЛЕМЕНТ БОЛОХ СОЁЛЫН МЭДЛЭГТ АНХААРАХ ЗРЭЛТ ХЭРЭГЦЭЭ

Судалгааны түүврийн анхан шатны нэгж буюу сонгогдсон сургуулийн 4-5, 8-12-р ангийн сурагчдын нэрсийн жагсаалтаас системчилсэн санамсаргүй болон зорилтот түүврийн аргаар 20-30 (тухайн сургуульд суралцаж буй хэлний цөөнх сурагчдын тооноос хамааран) сурагчдыг сонгон авч судалгаанд хамруулсан.

Асуулгад оролцсон зорилтот бүлгийн сурагчдын 51.2% нь урианхай, 19.8% нь Тува, 18.5% нь Казах, 5.1% нь Халх, 3.2% нь Дөрвөд үлдсэн 1.9% нь бусад (Түрк) угсаатны сурагчид байна. (График 1)



Сурч боловсрох эрхтэй холбоотой олон улсын гэрээ конвенц, холбогдох баримт бичиг, боловсролын талаар баримталж буй бодлого болон холбогдох дүрэм журам, зохицуулалт, багшлах боловсон хүчин бэлтгэж буй байдал, ном сурах бичгийн хүртээмж, хангалт, дотуур байран дахь хүүхэд хамгааллын бодлого, сургалтын хөтөлбөр зэрэгт баримт бичгийн шинжилгээ хийсэн. 6 сургуулийн 85 багш, 311 сурагчаас асуулга (11-18 настай) авсан ба 7 сургуулийн 169 эцэг эх, 67 багш, 66 сурагчид, 11 удирдлага, удирдах албан тушаалтнаас ярилцлагын аргаар мэдээлэл цуглуулсан.

Сонгосон сургуулиудын зааж буй хичээлийн зохион байгуулалт, үйл явц, багшлах боловсон хүчний чадвар, сурах бичгийн хангалт, сургалтын материал/хэрэглэгдэхүүн, сургалтад шаардлагатай техник технологийн хэрэгслийн хангалт/хүртээмж/хэрэглээ, суралцах орчны нөхцөл байдалд ажиглалт хийн судалгааны мэдээлэл цуглуулаа. Нийт 5 сургуулийн 117 сурагчдаас (9-11 настай) оролцоот үнэлгээний аргаар мэдээлэл цуглуулсан болно.

Судалгааны үндсэн хэсэг

1. Сурч боловсрох эрхийн хүртээмжтэй байдалд хийсэн нөхцөл байдлын үнэлгээ

- Багш нар нь сайн бэлтгэгдэж, сургагдсан эсэх

Асуулгад оролцсон нийт багш нарын 2 багш тутмын нэг нь буюу 55.3% нь казах, 4 багш тутмын 1 нь буюу 25.9% нь халх, 10 багш тутмын 1 нь 10.6% нь урианхай, үлдсэн 4.7% нь дөрвөд, тува (2.4%) болон бусад угсаатны (1.2%) багш нар байна. Энэ үзүүлэлтээс зарим багш нар өөрийн ажиллаж байгаа байгууллагадаа хэлний цөөнх бүлгийн хүн ам болж байгааг харж болохоор байна.

Цаашлаад тухайн орон нутгийн нөхцөл байдал, зонхилж байгаа угсаатны давамгайл бүлэг нь эрх мэдлээ урвуулан ашиглаж, чадвартай багшлах боловсон хүчинг шударгаар ажилд шалгаруулан авахгүй, гарал угсаа, эдийн засгийн статусаар нь ялгаварлан гадуурхах, шинээр ажлын байр бий болгох, багшийн тоог нэмэх, хасах асуудал нийтлэг байна. Мөн иргэд, төрийн албан хаагчдын дунд аймгийн ЗДТГ, түүний харьяа Боловсрол, соёлын газрын зүгээс чиг үүргээ хуулийн дагуу ялгаварлан гадуурхахгүй, үр дүнтэй явуулдагт бүрэн итгэлгүй байгаа хандлага ажиглагдаж байлаа.

Сургуулийн багш, ажилтан, эцэг эхийн төлөөллийн зүгээс ашиг сонирхлын зөрчилтэй байдлаар, ялангуяа танил тал, хамаатан садан эсвэл сумын түвшинд багшлах эрхийн гэрчилгээгүй эсвэл мэргэжлийн дипломтой ч үр чадвар муутай, туршлагагүй хүнийг ажилд авах тохиолдол түгээмэл байгааг цохон тэмдэглэсэн юм.

2. Сурч боловсрох эрхийн хүрэлцээтэй байдалд хийсэн нөхцөл байдлын үнэлгээ

- Боловсрол нь бүгдэд аливаа ялгаварлалгүйгээр (арьсны өнгө, яс үндэс, хэл, шашин, нийгэм, эдийн засгийн байдал гэх мэт) хүрэлцээтэй эсэх

Монгол Улсын үндэсний хууль тогтоомж, хүний эрхийн олон улсын гэрээний дагуу аливаа хүнийг ямарваа нэгэн байдлаар ялгаварлан гадуурхахыг хориглосон боловч тус судалгааны явцад оршин суугаа газар, байрлал, дэд бүтэц, угсаа гарвал, нийгмийн байдлаас шалтгаалан сурч боловсрох эрхээ эдлэхэд суралцагчид болон тэдний гэр бүлийн гишүүдэд саад тотгор учирсаар байна. Тодруулбал, хичээл заах үед зааварчилгааг эх хэл эсвэл давамгайл бүлгийн ярьдаг хэлээр ярихыг илүүд үздэг, сургалтын хөтөлбөр, хичээлийн агуулгаа суралцагчийн хэрэгцээтэй уялдуулан анхаардаггүй, багшийн зүгээс өөрт амар хялбар арга замыг сонгодог тохиолдол байна.

Хос хэлний боловсрол эзэмшиж чадахгүй байх, давамгайл хэлийг мэдэхгүйн улмаас ангийнхан, үе тэнгийнхэнтэй харилцахад бэрхшээл учрах, хичээлийн заавраа бүрэн ойлгохгүй учир бусдаас сурлагаар хоцрогдох, үе тэнгийнхэн хоорондоо бие биенээ үндэс угсаа, хэлээр ялгаварлан гадуурхах хандлага түгээмэл байна. Мөн хичээлийн бус цагаар өөрийгөө хөгжүүлэх секц, дугуйланд явах хүсэлтэй, явдаг суралцагчдын тухайд угсаа гарвалаар гадуурхах хүүхдүүдээс айх, тааралдахгүй байх, нэг бол

зодолдохоос айж явахгүй байхад хүрдэг. Тэмцээн, уралдаанд оролцох боломж бүрдсэн үед санхүүгийн дэмжлэг дутах, замын зардлаа олохгүй байх нөхцөл үүсдэг. Давамгайл бүлгийн дунд дотуур байранд амьдарч байгаа хэлний цөөнх суралцагчдын хувьд анги дэвших тусам сургуулийн багш, ажилтан, үе тэнгийнхний зүгээс ялгаварлан гадуурхах, зодох, шийтгэх, дээрэлхэх үзэгдэл улам нэмэгддэг гэж бүлгийн ярилцлагын үеэр онцолсон билээ.

3. Сурч боловсрох эрхийн хүлээн зөвшөөрөгдөхүйц байдалд хийсэн нөхцөл байдлын үнэлгээ

- Агуулга нь үл ялгаварласан эсэх

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2009 оны 131 дүгээр тушаалын дагуу “Ерөнхий боловсролын сургуулийн сурах бичгийг зохиох, хэвлүүлэх, түгээх журам”-ыг мөрдөж, боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага буюу хүрээлэн агуулга, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах үүрэг хүлээдэг.

Бага, дунд боловсролын хэвлэмэл сурах бичиг тавигдах шаардлага (MNS 5418:2008) стандартад боловсрол эзэмших тэгш байдлыг хангасан байх, үндэсний хэл, сэтгэлгээ, түүх, соёлын онцлогийг хүн төрөлхтний дэвшилтэт үнэт зүйлстэй хослуулсан байх ерөнхий шаардлагуудыг тогтоожээ. Энэ судалгааны хүрээнд агуулга, хөтөлбөрийг энэ чиглэлээр нарийвчлан судлаагүй.

- Соёлын мэдрэмжтэй эсэх

Энэ талаар нарийвчилсан судалгаа байхгүй, нарийвчлан тусгасан зохицуулалтгүй болно. Багш, эцэг эх, суралцагчийн зүгээс давамгайл бүлэг, соёл хоорондын харилцан ойлголцлын талаар хариулахдаа “Цагаан сар”, “Наурыз” зэрэг баяраар уламжлалт хувцсаа өмсөх, багш нар өөрсдийн санаачилгаар тэмдэглэлт өдөр, баярын талаар нэг өдрийн арга хэмжээ зохион байгуулахаас хэтэрдэггүй хэмээн тэмдэглэж байлаа.

- Сургууль нь аюулгүй, хүчирхийлэлгүй, эрүүл мэндийн наад захын стандарт хангадаг эсэх

Сургуулийн орчин нь хүүхдүүдэд биет байдал болоод сэтгэл зүйн хувьд аюулгүй, хүчирхийлэлгүй байх ёстой ч судалгаанд хамрагдсан бүх сургуулийн сурагчид, багш нар сургууль дээр үндэс угсаа, хэл, соёлд суурилсан хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалт ямар нэг байдлаар байдаг гэсэн хариулт өгчээ. Түүнчлэн хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалт нь бүх үндэстэн, угсаатны хүүхдэд тохиолддог гэдэг нь асуулга болон ярилцлагаар цуглуулсан баримтаар нотлогдож байна.

График 2: Сургууль дээрх хүчирхийллийн байдал (n=156/155)





График 3: Сургууль дээрх хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалт (Багш нарын хариулт)



4. Сурч боловсрох эрхийн цаг үетэйгээ зохицсон байдалд хийсэн нөхцөл байдлын үнэлгээ

- Хэл, соёлын цөөнхүүдэд боловсролыг чанартай хүргэдэг эсэх (үндэсний хэл соёлыг өөрийн хэл соёлтой хослуулан суралцдаг эсэх)

Асуулгад хамрагдсан сурагчдаас сургуульд нь таалагддаггүй 3 зүйлийг асуухад дараах асуудлууд хамгийн их давхцсан байна. Үүнд:

Зорилтот бүлгийн сурагчид	Хяналтын бүлгийн сурагчид
<ul style="list-style-type: none"> • Суралцах дотоод орчин • Багш нар сурагчдыг угсаатнаар ялгаварладаг • Багш, сургуулийн ажилтнуудын ёс зүй харилцаа 	<ul style="list-style-type: none"> • Суралцах дотоод орчин • Ус ариун цэврийн байгууламж • Багш, сургуулийн ажилтнуудын ёс зүй харилцаа
<ul style="list-style-type: none"> • Суралцах дотоод орчин • Багш нар сурагчдыг угсаатнаар ялгаварладаг • Хүүхдүүд бие биенээ угсаатнаар ялгаварладаг 	<ul style="list-style-type: none"> • Суралцах дотоод орчин • Багш, сургуулийн ажилтнуудын ёс зүй харилцаа • Хүүхдүүдийн харилцаа, үе тэнгийн дарамт
<ul style="list-style-type: none"> • Суралцах дотоод орчин • Багш, сургуулийн ажилтнуудын ёс зүй харилцаа • Багшийн чадвар заар арга зүй 	<ul style="list-style-type: none"> • Суралцах дотоод орчин • Багш, сургуулийн ажилтнуудын ёс зүй харилцаа • Хүүхдүүдийн харилцаа, үе тэнгийн дарамт

Хэлний цөөнхийн хэл, соёлоо уламжлан хадгалах нэг алхам нь хэлээ өөрийн хүүхдэд уламжлуулан үлдээх байдаг. Гэтэл сургууль, олон нийтийн газарт үе тэнгийнхэн, зарим тохиолдолд сургуулийн багш, ажилтан угсаа гарвалаар ялгаварлан гадуурхах, хүчирхийлэх явдал түгээмэл байна. Төрийн өмчийн сургуулийн материаллаг орчин суралцагчдад ээлтэй, таатай байж чадахгүй байснаар чанартай боловсрол эзэмшихэд сөрөг нөлөөлөхийн хамт багш, сургуулийн ажилтны зүгээс ёс зүйгүй харьцдаг, дорд үздэг, зарим тохиолдолд зодох, шийтгэх байдлаар харьцах нь нийтлэг байна. Гэр бүл, олон нийт, суралцах орон зайн үүлзвар болсон сургуульд насанд хүрэгчид соёл хоорондын диалог огт үүсгэхгүй, таагүй харьцааг улам хөхиүлэн дэмжсэнээр хүүхдүүд нэг нэгнээ угсаатнаар ялгаварлан гадуурхах, нэг нэгэндээ халдах, доромжлох, хүчирхийлэх болжээ.

Судалгааны үр дүн

Боловсрол ба соёлын мэдлэг 3 байдлаар үндэсний хэмжээнд мөрдөгддөг сургалтын хөтөлбөртэй болон хос хэлний боловсролын асуудалтай холбогдож байна. Үүнд:

1. Хос хэлээр суралцаж байгаа үндэстний цөөнхийн хүүхдийн сургалтын агуулга, хөтөлбөрт тухайн үндэстний соёлын агуулга тусах буюу сургалтын

хөтөлбөрийн нийцлийн асуудал

2. Үндэсний цөм/сайжруулсан сургалтын хөтөлбөрт үндэстний цөөнхийн соёл, түүхийг заавал тусгах болон дэлхийн бусад соёлын талаарх мэдлэг тусгалаа олох буюу олон соёлын боловсролын асуудал
3. Соёл хоорондын боловсрол олгох агуулга, цогц чадамж нь иргэний боловсрол болон нийгмийн ухааны бусад хичээлийн агуулгад тусгалаа олох буюу Дэлхийн иргэний боловсролыг (ТХЗ 4.7) сургалтын хөтөлбөрт интеграцчилах асуудал

Боловсрол ба соёлын мэдлэг нь үндэсний хэмжээнд мөрдөгддөг сургалтын хөтөлбөртэй болон хос хэлний боловсролын асуудалтай холбогдох дараах 3 хүрээнд дүгнэлт хийж байна.

1. Хос хэлээр суралцаж байгаа үндэстний цөөнхийн хүүхдийн сургалтын агуулга, хөтөлбөрт тухайн үндэстний соёлын агуулга тусах буюу сургалтын хөтөлбөрийн нийцийн асуудал

Боловсролын зорилго нь хүүхэд нийгмийн үр бүтээлтэй гишүүн, улс орныхоо хариуцлагатай иргэн болоход шаардагдах мэдлэг, ур чадвар, хандлагад суралцахад туслахад оршдог. Амжилттай суралцахад зайлшгүй хэрэгцээтэй нөхцөл нь төрөөс хичээл, түвшин нэг бүрээр тогтоосон сургалтын хөтөлбөрт заасан суралцахуйн цогц чадамжийг эзэмших явдал.

Дээрх зорилтыг хангахын тулд Баян-өлгий аймагт амьдран суудаг үндэстний цөөнхийн казах, тува хүүхдүүдэд үндэсний сайжруулсан хөтөлбөрийг хүргэхдээ тэдний төрөлх хэлийг бага боловсролын түвшинд сургалтын хэлээр ашигладаг ба суурь боловсролын түвшнээс албан ёсны хэл болох монгол хэл дээр сургалтыг зохион байгуулдаг. Гэтэл удаа дараагийн казах, монгол хэлний сорилууд, унших, математикийн чадварын шалгалтууд, чанарын судалгааны дүнгээр эдгээр суралцагчдын эх хэлний болон монгол хэлний мэдлэг, ур чадвар үндэстний олонх хүүхдүүдтэй харьцуулахад доогуур гарч байна.

Асуудлын уг шалтгааныг судлах явцад сургалтын хөтөлбөр ба сургалтын материал хэрэглэгдэхүүнтэй холбоотойгоор соёлын мэдлэгийн хүчин зүйл товойн гарч ирснийг гүнзгийрүүлэн авч үзсэн болно. Монгол улсад бага, суурь, бүрэн дүнд боловсролын сайжруулсан сургалтын хөтөлбөрийг мөрдөж байгаа бөгөөд уг хөтөлбөрийн дагуу зохиогдсон сурах бичгүүдийг орчуулан хэрэглэж байна.

Бага насны хүүхдүүдийн хэлийг ашиглах чадвар, хэлсэн болон бичсэн үгийн утгыг сонсох, ойлгох чадавх нь унших, бичих, үсэглэх зэрэг дараагийн бичиг үсэгт тайлагдахад нөлөөтэй гэж судлаачид бичиж байна. Уншихын зорилго бол ойлгох, өөрийн өмнө олж авсан мэдлэгээ уншиж байгаа зүйлтэйгээ холбож чадвал хүүхэд ойлгодог. Хүүхдийн өөрийн мэддэг хэл, соёл, газар зүй дээр суурилагагүй унших материал, хэрэглэгдэхүүнгүй байх нь түүнийг хохироодог. (Prouty, 2009)

Хичээл, сурах бичиг давамгайлсан соёлд голлон анхаарч, үндэстний цөөнх

суралцагчдын гэр бүл, орон нутгаасаа олж авсан/сурсан мэдлэг, үр чадварыг үл ойшоодог. Ингэснээр сургуульд ороод шинээр сурах ёстой зүйлээ ойлгоход туслах ёстой өөрсдийн өмнө сурсан, мэдсэн зүйлээ ашиглаж чадахгүйд хүрдэг.

Танил хүн, газар орон, үйл ажиллагааны талаарх эх, зураг, түүх нь эдгээр суралцагчдын ойлгох, унших, бичих үйл ажиллагааг утгатай, утгын холбоотой болгодог тул тэд үгийг зөв хэлж, ашиглаж, ярьж харилцаж, өгүүлбэр болгон бичиж сурч байгааг хос хэлний хөтөлбөр хэрэгжүүлэгчид олж харсан байна.

Хос хэлний сайн хөтөлбөрүүдийн амжилттай хэрэгжүүлсний үр дүнг дараах байдлаар тодорхойлжээ.

Хос хэлт суралцагч: сургуульд сурахдаа болон өөрийн орон нутаг, улс орондоо бусадтай харилцахдаа 2 хэлийг итгэлтэйгээр ашигладаг.

Хос бичиг үсэгт тайлагдсан: хоёр хэл дээр ойлгож, уншиж, бичдэг.

Хос соёлтон: Өөрийн үндэстэн, орон нутгийн соёлыг хайрлан дээдлэхийн зэрэгцээ өөрөөс ялгаатай харагддаг, ярьдаг, итгэл үнэмшилтэй хүмүүстэй өөртөө итгэлтэйгээр, хүндэтгэлтэйгээр харилцаж чаддаг

Амжилттай суралцагч: өөрт тавьсан боловсролын зорилгоо биелүүлж, насан туршдаа суралцах дур сонирхолтой болсон байна.

Хос хэлний хөтөлбөрөөр сурч байгаа суралцагчдад хөтөлбөрийн зорилго нь дараах 3 чиглэлд байхаар тодорхойлдог:

- Хэл эзэмших зорилго: суралцагч эх хэл болон төрийн албан ёсны хэлээр ойлгох, ярих, унших, бичих бүрэн чадвартай болох, бусадтай харилцах ба насан туршдаа суралцахад хэрэглэх итгэл төгс байх
- Академик зорилго: Анги түвшин бүрд, хичээл нэг бүрээр тавьсан суралцахуйн цогц чадамжийг эзэмших, цаашид үргэлжлүүлэн сурахад бэлтгэгдэх
- Нийгэм-соёлын зорилго: Суралцагчид өөрт нь өвлөгдөн ирсэн хэл, соёлыг хайрлах, хүндэтгэх, мөн өөрөөсөө ялгаатай хэл, соёл, итгэл үнэмшлийг хүндэтгэх, талархан хүлээн авах

Монгол эх хэлтэй суралцагчдад зориулсан үндэсний хөтөлбөрт адаптаци хийх замаар эх хэл нь өөр суралцагчдад тохируулж дээрх зорилгыг хэрэгжүүлдэг. Тухайлбал,

- Математик, байгалийн шинжлэл, нийгмийн ухааны болон бусад академик хичээлийн цогц чадамж нэг адил байх ба бүх суралцагчид эдгээр хичээлүүдийг ойлгохдоо хэлээ ашигладаг.
- Хос хэлний хөтөлбөрөөр суралцагчдын хувьд эх хэлийг тусдаа хичээл болгож заах ба сонсох, ярих чадварыг хөгжүүлэх, улмаар эх хэлээрээ унших, бичих чадварт сургах цогц чадамжийг хөгжүүлнэ.
- Төрийн албан ёсны хэлийг мөн тусдаа хичээл болгон заах ба тухайн хэлээр уншиж, бичих чадварт сурахаасаа өмнө ойлгож, ярьдаг чадвартай болгоход анхаарна. Бага ангид төрийн албан ёсны хэлийг заахдаа ярианы хэлийг

ХОС ХЭЛНИЙ СУРГАЛТЫН НЭГ ЭЛЕМЕНТ БОЛОХ СОЁЛЫН МЭДЛЭГТ АНХААРАХ ЭРЭЛТ ХЭРЭГЦЭЭ

хөгжүүлэх, үгийн нөөцийг нэмэгдүүлэх, дүрмийг ойлгуулахад сургалтын хөтөлбөр чиглэх ёстой. 2-3 эсвэл 2-4 ангид эх хэлээрээ унших, бичих чадварыг албан ёсны хэлээр унших, бичих чадвартай гүүрлэн холбоход сургалтын хөтөлбөр чиглэнэ. Бага боловсролын төгсгөл рүү дараагийн шатны боловсролд бэлтгэх буюу “өдөр тутмын” хийсвэр ярианы хэлийг өргөжүүлэн тэлж, илүү нарийн бүтэцтэй, урт эхүүдийг унших, бичих чадварыг бүрэн гүйцэт эзэмшихэд тусална.

- Албан ёсны хөтөлбөрт туссан бусад нэмэлт хэлүүдийг үзэж судалдаг ч эх хэл болон төрийн албан ёсны хэлний бат бэх суурь тавигдсаны дараа эхлүүлэх чиглэлийг барих нь зөв гэж үздэг.

Сургалтын хэрэглэгдэхүүн

Сургалтын хэрэглэгдэхүүнийг хөтөлбөр хэрэгжүүлэх эхний өдрөөс хэрэглэх боломжтойгоор бэлтгэх нь зүйтэй. Сургалтын хэрэглэгдэхүүнийг бэлтгэхдээ унаган хэлтэй хүмүүсийн бичих, зурах, дүрслэх болон унших болон бусад сургалтын материалыг хянан шүүх чадавхийг дайчлан ашиглах нь зүйтэй. Бага ангиудад энгийн зурагтай, энгийн хэвлэмэл хямд төсөр хэрэглэгдэхүүнийг ашиглах нь оновчтой байна.

Унших материалд тавигдах шаардлага:

- Агуулга сонирхолтой байх
- Тодорхой, ойлгомжтой байх
- Зураг дүрслэл нь эхтэй холбоотой, соёлын хувьд нийлэмжтэй байх
- Материалууд нь анги ахих тусам богино товч байдлаас нарийн нийлмэл дэлгэрэнгүй байдал руу шилжих

Унших материал бэлтгэх үе шатууд			
1 үе шат Эх хэл	2 үе шат Эх хэл	3 үе шат 2 дахь хэл/албан ёсны хэл	4 үе шат Эх хэл ба/эсвэл 2 дахь хэл
Хэнд: Эхлэн уншигчдад	Хэнд: Унших суурь чадвар эзэмшсэн уншигчдад	Хэнд: Шинэ үзсэн хэлээр уншихад бэлэн болсон уншигчдад	Хэнд: Эх хэл болон 2 дахь хэлээр уншигчдад
Зорилго: бичмэл эх утга илэрхийлдэг гэдгийг сурах, уншиж чадна гэсэн итгэлтэй болох	Зорилго: сайн уншиж сургах, сурах зорилгоор уншиж сурах	Зорилго: эх хэл дээр уншиж сурсан аргаа 2 дахь хэл дээр уншиж эхлэхэд ашиглах	Зорилго: сурахын тулд болон өөрийн сонирхлоор унших
Хэмжээ/агуулга: Богино ба энгийн, танил сэдвийн хүрээнд	Хэмжээ/агуулга: Уртавтар, тухайн орон нутгийн соёлын талаар болон танил бус сэдвээр байх	Хэмжээ/агуулга: эхний шаттай адил	Хэмжээ/агуулга: хэмжээ ямар ч байж болно. Эх хэл, соёлоос гадна тухайн орон нутгаас бусад нутаг, улс орны талаарх олон төрлийн сэдэв байх

Бусад улс үндэстнүүдийн соёлын олон янзат байдал, түүх уламжлалын талаар үзэж байгаа хэл дээр нь унших материал бэлтгэх, ном, хэвлэлүүд номын сангаар бэлэн байлгах нь мөн ач холбогдолтой.

Орон нутгийн иргэд, эцэг эхчүүд бэлтгэсэн материалыг уншиж зөвшөөрөх нь чухлыг судлаачид хэлж байна. Зарим тохиолдолд давамгайлсан соёлын үүднээс боловсруулсан материалууд тухайн соёлын талаар хэвшмэл ойлголтыг батжуулж, ялгаварлан гадуурхсан, дорд үзсэн өнцгөөс бичсэн, боловсруулагдсан байх магадлал өндөр байдаг. Тухайн үндэстний түүх, соёлын талаар ташаа зөрүүтэй мэдээлэл оруулах, нэр томъёог оновчгүй хэрэглэх, эсвэл хязгаарлагдмал хүрээнд буюу хоол, дуу хөгжим, бүжиг, хувцас зэрэг өнгөц мэдээлэл оруулах магадлал өндөр тул соёлын экспертүүдийг хөтөлбөр, сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулахад хамран ажилласан сайн туршлага бусад улс оронд байна.

2. Үндэсний цөм/сайжруулсан сургалтын хөтөлбөрт үндэстний цөөнхийн соёл, түүхийг заавал тусгах болон дэлхийн бусад соёлын талаарх мэдлэг тусгалаа олох буюу олон соёлын боловсролын асуудал

Цөм хөтөлбөр үндэсний хэл, соёл, түүх, уламжлалаа хүндэтгэн, өвлөн хөгжүүлдэг хүн төлөвшүүлэхэд анхаарах нь гарцаагүй чухал. Гэхдээ уламжлалт соёл дахь нийгмийн тодорхой анги, категорийг дорд үзсэн, ялгаварласан, эрхийг нь зөрчсөн агуулгыг багтааж болзошгүй нөхцөлийг давхар агуулж байгааг анхаарууштай гэж судлаачид дүгнэсэн байдаг.

Суурь боловсролын сургалтын арга зүйн хэсэг нь сурагч бүрийн шинжлэн судлах, асуудал шийдвэрлэх арга барилыг хөгжүүлэхэд анхаарч байна. Эдгээр сургалтын арга зүй нь сурах үйл ажиллагаанд сурагч бүрт янз бүрийн эх сурвалжийг судлах замаар нэг үнэнд эргэлзээтэй хандан шинэ мэдлэгийг бүтээх, өөр хувилбарыг дэвшүүлэх боломжийг олгодог. Энэ бүхэн нь сурагчдад нийгмийн зонхилгоо хэсгийнхнээс ялгаатай байхыг хүлээн зөвшөөрдөг хандлага төлөвшихөд эерэг нөлөөтэй.(Ц.Одгэрэл, С.Түмэндэлгэр, 2016)

Суурь боловсролын нийгмийн ухааны хөтөлбөрт “СОЁЛ” хэмээн бүлэг сэдэв 7-11 ангид орж байна. Суралцагчдыг амьдарч буй нийгмийн орчинд, гэр бүл, сургуулийн орчинд бусдын соёлыг ойлгодог, хүндэтгэдэг эрмэлзлэлтэй болж, үйлдлээрээ илтгэн харуулдаг болгох бөгөөд олон соёлын нөхцөлд зохицон амьдрах чадварт суралцана гэж зорилгоо тодорхойлжээ. Соёлын олон янз байдлыг арьс өнгө, угсаа гарвал, нийгэм-эдийн засгийн байдал, нас, бие махбодын чадвар, шашин шүтлэг улс төрийн итгэл үнэмшил зэрэг өргөн хүрээд тодорхойлсон бөгөөд ялгаатай соёлд хүндэтгэлтэй хандах, танин мэдэх, ойлгох, харилцан ойлгох, хүлээцтэй тэвчээртэй байх чадваруудад сургахаар оруулсан нь чухал юм.

Соёлын олон янз байдалд зохицон амьдрах нь нийгмийн тогтвортой хөгжлийн нэг чухал хүчин зүйл гэсэн өнцгөөс агуулгуудыг сонгосон байв. Соёлын зөрчилдөөн гэдэг ойлголтыг оруулж ирэн, бусдыг үзэн ядах, шударга бус хандах, нийгмийн хүрээнээс шахах, зайлуулах үйлдлийг ойлгох, зайлсхийхийн чухлыг суралцагчдад

ойлгуулах шаардлагатай гэж үзсэн байна. Хүнийг ялгаварлах, аль нэг бүлэг, үндэстнийг бусдаас ангид тэргүүнд байх ёстой гэж үздэг байсан түүхийн үеийг санах, сургамж авах зэрэг агуулгыг оруулсан нь сайшаалтай.

Хүний эрхийн түгээмэл тунхаглал 26-р зүйлд “Боловсрол нь аливаа улс түмэн, янз бүрийн арьстан хийгээд шашны бүлгүүд бие биеэ харилцан ойлгох, хүлцэн тэвчих, эвсэн найрамдахад” дөхөм үзүүлэх ёстой гэж заасан байдаг ба НҮБ болон бусад олон улсын байгууллагын конвенциуд нь аливаа улс орнуудад хэл соёлын ялгаатай иргэдэд чиглэсэн бодлого хэрэгжүүлэхдээ хэл болон боловсролоор дамжуулж үндэстэн хоорондын ойлголцлыг сайжруулах зарчим баримталдаг:

- Үндэсний онцлог бүхий хичээлүүдийн сургалтын агуулгад соёлын ялгаатай байдлыг хос хэлний болон үндэсний хөтөлбөрт аль алинд нь тусгах
- Үндэстэн хоорондын ойлголцол, бусад соёлд хүндэтгэлтэй хандахад сургах замаар өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлж, Үндэстний соёл үнэт зүйлийн үнэгүйдлээс урьдчилан сэргийлж, стереотип/хэвшмэл ойлголтыг арилгадаг. (Х. Бейбитгүл, 2020)

Боловсрол нь соёлын оршин тогтнох амин чухал зүйл юм. Хамтын ба түүхийн үзэгдэл болохын хувьд соёл нь боловсролоор үеэс үед дамжиж, баяжигдаж байдаг. Зохион байгуулалттай боловсролын зорилго ч энэ байдаг. Сургалт явуулах хэлийг сонгох, түүх, газар зүй, нийгэм судлал, шашин судлал зэрэг иргэний боловсролын хичээлийн агуулгыг тодорхойлох зэрэгт энэ асуудал хамгийн тод илэрдэг.

Боловсролын агуулгыг сонгох 4 хандлагыг судлаачид тодорхойлохдоо (1) уусгах (таарч нийцэхүйц болох, бусадтай адилхан болгох), (2) соёлын өвийн (хөтөлбөрт олон соёлын элементүүдийг тусгаж өргөтгөх, томсгох), (3) билэг тэмдгийн ялгаатай байдлын хандлага (хөтөлбөр хэвээр, соёл, шашин, ёс заншлын тодорхой харагдах байдлыг зөвшөөрөх), (4) олон соёлын хандлага (сурагчдын ялгаатай байдлыг баялаг гэж харах) чиг хандлагатай байдаг гэжээ. (Raveaud, 2008)

Сургалтын хөтөлбөрт ассимиляциас илүүтэй интеграци (тэгш хамруулсан орчин нөхцөлд харъяалагдах) хандлагыг баримтлахыг санал болгожээ. (Rader 2018) Интеграци нь хүний амин чанар, ялгаатай байдлыг хүндэтгэн үзэж, тэгш хамруулсан орон нутаг, нийгмийг бий болгохыг зорьдог. Интеграци бие биетэйгээ харилцах, хамтрах “хуваалцсан” хариуцлага бөгөөд “хүрч очих” үзэл баримтлал буюу нэг хэсэг нь өөрийн хэл соёлыг хадгалангаа шинэ соёл, хэлийг хүлээн авах “хүрч очих”, нөгөө тал нь “гарч очих” үзэл баримтлал буюу нөгөө талын хэл соёлыг хүлээн авах хариуцлага хүлээх гэсэн 2 хэсгээс бүрдэг болохыг тайлбарлажээ.

Хүмүүс бид бие биенийхээ хэл дээр мэндчилгээ сурч, ойр зуурын үг, хэллэгийг сурч ашиглаж, бие биетэйгээ хэлээр нь харилцахыг эрхэмлэх, хичээх; хүмүүс бие биенийхээ соёл, ёс заншлыг сонирхох, мэдэж авахыг хичээх; хүмүүс бие биенийгээ олон нийтийн болон орон нутгийнхаа үйл явдал, үйл ажиллагаанд урьж оролцуулах (Rader 2018) зэрэг сургуулийн болон тухайн орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх үйл ажиллагаанууд их нэмэртэйг онцолж байна.

Сургалтын агуулгын хувьд “баяр ёслол, хоол хүнс, бүжиг наадмын хандлагаас”

өөрөөр бүх хичээлд шигтгэх, илүү гүнзгий ойлголт өгөх, (Coulby, 2006), соёл хоорондын онолд түүхэн, хүн ам зүйн, улс төрийн, харьцуулсан контекстыг авч үзэж агуулгыг гүнзгийрүүлэх, улмаар даяаршлын өргөн хүрээнд авч үзэх нь чухал гэж анхааруулж байна.

Сургалтын хөтөлбөрийн суурь нь нийгмийн шударга ёс, эрх тэгш байдал, хүний эрхийг хангах байх ба сургалтын хөтөлбөр нь хэвшмэл ойлголт, үхвар мөчид төсөөлөл, арьс үндсээр ялгаварлах үзэл болон бусад ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийн эсрэг идэвхтэй байр сууринаас хандах, сурагчдыг нийгмийн өөрчлөлтийн төлөө идэвхтэй ажиллах, эрх мэдлийг олгох зорилготой байх нь зүйтэй гэж үзэж байна.

Арга зүйн хувьд өөр зүйл заах гэж байгаа биш, өөрөөр заах тухайд, өөрөөр хэлбэл “түүх, газар зүй, хэл, соёл, философи, хүмүүн төрөлхтөн, нийгмийн талаар шинэ санаа өгөх”, хичээл хоорондын уялдаа холбоог хангасан арга зүйг хэрэглэх, багаар хичээл заах, эл сурахдаа соёлыг хамт сурах зэрэг аргуудыг хэрэглэхийг санал болгож байна.

Өөрийн соёлыг бусдын соёлын хамт судлах нь танин мэдэхүйн, сэтгэл хөдлөл-мэдрэмжийн, зан байдлын хэд хэдэн цогц чадамжуудад суурилна:

- Мэдлэг: өөр соёлтой бүлгүүд, тэдний практик амьдрал, бүтээл болон өөр соёлтой хүмүүс хэрхэн харилцдаг арга замуудын талаар мэдлэгтэй байх
- Хандлага: сониуч зан, нээлттэй байдал, бусдыг хүндэтгэх, тэдний оронд өөрийгөө тавих,
- Тайлбарлах ба холбох үр чадвар: өөр соёлын практикийг тайлбарлах, өөрийн соёлын практиктай холбох
- Нээлт хийх үр чадвар: соёл, түүний практик, бүтээлийн талаар эрэл хайгуул хийж, шинэ мэдлэг эзэмших
- Соёлын талаарх шүүмжлэлт мэдлэг ойлголт: өөрийн болон бусдын соёлын практик ба бүтээлийг шүүмжлэлт байдлаар үнэлж цэгнэх

3. Соёл хоорондын боловсрол олгох агуулга, цогц чадамж нь иргэний боловсрол болон нийгмийн ухааны бусад хичээлийн агуулгад тусгалаа олох буюу Дэлхийн иргэний боловсролыг (ТХЗ 4.7) сургалтын хөтөлбөрт интеграцчилах асуудал

Өнөөдөр дэлхий дахинд боловсрол, хүний хөгжлийн үзэл хандлагыг ихээхэн өөрөөр авч үзэх болсноор тодорхой шинжлэх ухааны цогц мэдлэг олгож ирсэн уламжлалт хандлагаас татгалзаж, өсвөр үе, хүүхэд багачуудыг нийгмийн амьдралд бэлтгэх, “дэлхийн иргэн”³ болгон төлөвшүүлэх чиглэлээр бодлого, агуулга, арга зүйн шинэчлэлтүүд хийгдэж байна.

3 “Дэлхийн иргэн” гэдэг нь ямар нэгэн хууль эрх зүйн статус, харьяалал, гишүүнчлэлийн тухай ойлголт биш юм. Харин энэ бол хүн төрөлхтөний нэгэн эд хэсэг бөгөөд дэлхий нийтийн сайн сайхан байдал, тэгш, шударга, зөв нийгмийн төлөө хамтын хариуцлага хүлээж, хувь нэмрээ оруулах үзэл санаа, үйлдэл, үйл ажиллагаа хэмээн үзэж байна.

Хүн бүрд ээлтэй, тэгш, шударга дэлхий ертөнцийг бүтээх чадвартай, зохистой оролцоо бүхий иргэдийг төлөвшүүлэхэд иргэний боловсрол хамгийн чухал нөлөөтэй. Ийнхүү дэлхий нийтээр орчин цагийн боловсролд, түүний дотор хойч үе, залуучууддаа ямар иргэний боловсрол олгох вэ гэдэгт маш их анхаарч хөгжлийн одоогийн үйл явцтай холбон шинэ хандлагаар, шинэ загвараар авч үзэж байна. Гэтэл Монгол Улсын иргэний боловсролын агуулга, арга зүйд орчин цагийн засаглал, шударга ёс, хүний эрх, ёс суртахууны агуулга зонхилж чадахгүй, харин ч үндэсний өв уламжлал, түүхчилсэн соёл зэрэг байдал хэт давамгайлж байгаа дахин эргэж харах шаардлагатай байна. (Ч.Алтангэрэл, 2020)

Бид дэлхийн иргэний хувьд соёлын олон янз байдалтай нийгмийн нэг хэсэг, мөн нэг ангид соёлын олон янзай байдал зэрэгцэн байгаа нь бодит байдал мөн. Өөрөөсөө өөр соёлтой хүмүүст нээлттэй байх, тэднийг сонирхох, тэдний тухай олж мэдэхийг хүсэх, өөрийгөө тэдний оронд тавьж үзэх, энэхүү ондоо байдлын тухай мэдлэгээ бусадтай харилцахдаа хэрэглэх, нийтлэг зорилгын төлөө хамтран ажиллахад чиглэсэн соёл хоорондын үзлийг суулгах эрэлт хэрэгцээ нэгэнт үүссэн байна. Бидэнд соёл хоорондын боловсрол хэрэгтэй байна.

Соёл хоорондын боловсрол нь (Intercultural Education) соёлын янз бүрийн бүлгүүдийн хоорондын харилцан яриа, харилцан хүндэтгэл, харилцан ойлголцлыг бий болгох замаар олон үндэстний нийгэмд хамтдаа хөгжиж, тогтвортой амьдрах боломжийг бий болгох зорилготой юм. 1980-аад онд багшийн боловсролын хөтөлбөрт орж ирсэн агуулга бөгөөд 1990-ээд оноос анги тахимд ажиллаж байгаа багш нар илт сонирхож эхэлсэн ба мэргэжил дээглүүлэх үйл ажиллагаанд өргөнөөр түсгалаа олж байсан байна. Улмаар 2015 онд НҮБ-ын Ерөнхий Ассемблейн чуулганаар батлагдсан Тогтвортой хөгжлийн зорилгын 4.7-д Дэлхийн иргэний боловсролын агуулгад соёлын олон янзат байдал, хүлцэн тэвчих, соёл хоорондын харилцан ойлголцол, харилцан яриа, үндэстэн хоорондын эв эе, хамтын ажиллагаа, энх тайвнаар зэрэгцэн амьдрах тухай агуулгыг бүх суралцагчид олгох зорилго тавьсан. Дэлхийн иргэний боловсролын асуудлууд боловсролын бүх түвшинд, тухайлбал, (a) үндэсний боловсролын бодлогод, (b) хөтөлбөрт, (c) багш бэлтгэх боловсролд, (d) сурагчийн үнэлгээнд шигдсэн/нэвчсэн эсэх гэсэн шалгуур үзүүлэлтээр хэрэгжилтийг дүгнэхээр тохиролцоод байна. Хэрэгжилтийг үнэлэхдээ тоон ба чанарын хэмжүүр ашиглах ба “байгаа”, “дурдсан” гэдэг үнэлгээнээс давж, энэхүү боловсролыг олгож, нийгэмд өөрчлөлт гарч байна уу? гэдгийг харна гэдгээ ЮНЕСКО-гийн Статистикийн байгууллага удирдамждаа тодорхойлжээ.

Дэлхий дээр улс орнуудын түүхэн уламжлалт (хэл ба соёлын цөөнх, нутгийн уугуул иргэд зэргийг багтаасан) болон шилжилт хөдөлгөөний үр дүнд бий болсон соёлын олон төрлийг хүлээн зөвшөөрөх явдал өсөж байна. Соёлын олон төрөл нь өсөж хөгжихийн эх үүсвэр хэдий ч нийгмийн нэгдэл нягтрал хямралд орсон үед зөрчил үүсэх үндэс болж болох юм.

Соёл хоорондын харилцааны цогц чадамж (Intercultural competence) гэдэг нь өөрийнхөөсөө ялгаатай соёлтой хүмүүстэй нийцтэй, үр дүнтэй харилцахад хүргэх танин мэдэхүй, сэтгэл мэдрэмж, зан байдлын үр чадварын хүрээ юм. Энэ нь зөвхөн

олон улсын түвшинд, гадаад улс оронд очиход хэрэгтэй чадамж биш орон нутаг, бүс нутаг, үндэсний ба олон улсын түвшинд явагдах соёл хоорондын харилцааны асуудал гэж харах нь зохилтой.

Соёл хоорондын ойлголцол бий болгох үзэл баримтлалын хүрээг (Rader 2016) өөрсдөдөө, хүүхдэд, бие биендээ суулгах 4 цогц чадамжаар баримжаалж байна:

- Мэдлэг ба ойлголт;
- Итгэл үнэмшил, үнэт зүйл, хандлага;
- Соёл хоорондын ба харилцааны, амьдрах ухааны үр чадварууд;
- Эерэг үйлдэл хийх, оролцох

Хэрэгжүүлэх гол стратеги нь сургалтын хөтөлбөрт тусгах ба тусдаа хичээлээр үзэж болох ч (иргэний боловсрол), хөтөлбөр дамнасан байх нь чухлыг онцолж байна. Сургууль бүхэлдээ хандлага буюу хичээлээс гадуурх үйл ажиллагаа, тв нэвтрүүлэгээр гэх мэт бусад арга замуудыг ч үгүйсгэхгүй байна.

Монгол улсын үндэсний цөм хөтөлбөр болон бусад боловсролын бодлогын баримт бичгүүдэд дэлхийн иргэний боловсролын танин мэдэхүйн шинжтэй агуулгууд ямар нэг байдлаар туссан боловч соёл хоорондын боловсролын асуудал тусгалаа олоогүй, дэлхий нийтийн асуудлууд болон дэлхийн иргэний боловсролын гол сэдвүүд орхигдсон (үндэсний, бахархалт, хариуцлагатай иргэн гэх мэт) агуулга дунд болон ахлах ангид их, бусад түвшнүүдэд байхгүй, ялангуяа зан үйлийн цогц чадамжуудын хувьд жигд бус, сурах бичгийн агуулгад тусаагүй, нэмэлт материал дутмаг байна гэж 4 улсын сургалтын хөтөлбөрт ДИБ-ын агуулга хэрхэн туссан талаар дүн шинжилгээ хийсэн шинжээчид дүгнэсэн байна.

ДИБ-ыг шигтгэх оролдлого саяхны хөтөлбөрийн шинэчлэлд тусгасан боловч (нийгмийн ухааны хөтөлбөрт) “Хүний эрх”, “иргэний үүрэг хариуцлага”, “энх тайван”, “ардчилал”, байгаль орчны мэдлэг ойлголт, хамгаалал” хамгийн түгээмэл сэдвүүд байгаа ба одоохондоо уламжлал, ёс суртахууны хүрээнд баригдмал байгааг тодорхойлжээ. Дээрх агуулгаа шинэ үзэл баримтлалаар тэлэх мөн гүнзгийрүүлэх, дэлхийн түвшинтэй холбох, том зургаар харах, багш бэлтгэхэд анхаарах, багшийн гарын авлага, сургалтын хэрэглэгдэхүүнийг шинэчлэх, олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, дэмжлэг авах чухал байгааг зөвлөмжилжээ.

Багш бэлтгэх болон мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрт ДИБ хязгаарлагдмал байдалтай байгаа тул багш нар холбогдох агуулгуудыг заахад сайн бэлтгэгдээгүй байгааг судлаачид онцолж байгаа ба шалтгаан нь бусад агуулгад илүү их ач холбогдол өгөх, мөн багшлахуй, суралцахуйд баримталж байгаа давамгайлсан онол-хандлагатай холбоотой гэж үзэж байна. (Aktas et al. 2017; Bourn et al. 2017, McEvoy 2017, Gaudelli, 2016).

Боловсролын хүрээлэнгийн ЕБС, их дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт хийсэн шинжилгээний үр дүнгээс (2016) харахад танин мэдэхүй, нийгэмших, биеэ авч явах гурван ай хүрээнд бага, суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн зорилт, агуулга, аргазүйд зохих хэмжээгээр ДИБ-ын агуулга тусгалаа олсон байна. Тухайн сэдвүүд болон суралцахуйн зорилго, зорилтууд манай улсын ерөнхий боловсролын

одоо мөрдөж буй нийгмийн ухаан, иргэний боловсролын хөтөлбөр ба сургалтыг дэмжих үйл ажиллагааны агуулга, чиглэл, арга зүй, үнэлгээнд ямар нэг байдлаар тусгалаа олсон. Бага, суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөрт глобаль болон бүс нутгийн түвшний асуудал бага, харин тухайн улс үндэстний асуудал түлхүү тусгагдсан байна гэж үзжээ.

Сурагчийн үнэлгээнд тусгах чиглэлээр хүлээсэн үр дүнг тодорхойлох зөвшилцөлд хүрээгүй, өргөн хүрээнд ДИБ-ыг дэмжихэд хэрэгтэй мэдлэг, үр чадвар гэж тодорхойлсон боловч яг ямар гэдэг дээр зөвшилцөлд хүрээгүй, цаашилбал яг ямар хандлага, үнэт зүйл төлөвшүүлэх вэ гэдэг чиглэлээр зөвшилцөлд хүрээгүй байна. Энэ чиглэлээр байгуулагдсан ажлын хэсэг (Global Citizenship Education Working Group) дараах 8 ДИБ компетенцийг тодорхойлсон:

- 1.) өөрийгөө бусдын оронд тавих;
- 2.) Шүүн тунгаах/ асуудлыг шийдвэрлэх;
- 3.) Бусадтай харилцах, хамтрах чадвар;
- 4.) зөрчлийг шийдвэрлэх;
- 5.) амин чанараа мэдрэх ба аюулгүй байдал;
- 6.) дэлхий нийтийн нийтлэг үнэт зүйлс;
- 7.) нийгмийн ялгаатай байдлыг хүндэтгэх ба соёл хоорондын харилцан ойлголцол;
- 8.) дэлхий нийтийн тулгамдсан асуудлыг ба харилцан холбоотойгоо хүлээн зөвшөөрөх (байгаль орчны, нийгмийн, эдийн засгийн хувьд гэх мэт) (Brookings Institute, 2017).

Дүгнэлт Санал, зөвлөмж

“Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвсэл нь ХЭҮК-той хамтран Монгол улсын 3 үндэстний бүлэг хамтран амьдардаг Баян-өлгий аймагт хүүхдийн сурч боловсрох эрх хэрэгжиж байгаа нөхцөл байдлын үнэлгээ хийсэн билээ. Энэ судалгаагаар үе тэнгийнхэн хоорондоо бие биенээ үндэс угсаа, хэл, шашин, соёлоор ялгаварлан гадуурхах хандлага түгээмэл байгааг илрүүлсэн ба багш нар нь хүлээн зөвшөөрсөн байдаг. Олон нийтийн газар, сургуульд насанд хүрэгчид дээрх таагүй харьцааг өдөөснөөр хүүхдүүд нэг нэгнээ угсаа гарвалаар ялгаварлан гадуурхах, эрхэнд нь халдах, доромжлох, хүчирхийлэх явдал гарсаар байна гэдгийг шинжлэн тодруулсан байна. Мөн ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, бусдын эрхийг хүндэтгэх, соёл хоорондын харилцаа үүсгэх мэдлэг олгох, үр чадвар, үнэт зүйл төлөвшүүлэх эрэлт хэрэгцээ байгааг судлаачид дүгнэсэн байна.

Хэдийгээр асуулгад хамрагдсан сургуулийн багш нар бүгд их дээд сургуульд төгсч мэргэжил эзэмшсэн ч ёс зүй, заах арга зүй, хичээлийн агуулгыг хүргэж байгаа байдалд судалгаанд хамрагдсан сурагчид, тэдний эцэг эх болон сургуулийн удирдлага, зарим багш нар сэтгэл дундуур байна.

НҮБ-ын ТХЗ-ын 4.7 дахь дэд зорилтод “дэлхийн иргэншлийн боловсрол, энх тайвны соёлоор дамжуулан тогтвортой хөгжлийг хөхиүлэн дэмжих мэдлэг, үр чадвартай болох”-ыг тэмдэглэсэн юм. НҮБ-ын БШУСБ-аас нийтэлсэн Делорын болон Форын илтгэлд дурдсанаар аз жаргал, сайн сайхны төлөө өөрийн хувийн зан байдлаа өөрчлөх үр чадвар нь “хамтдаа харилцан амьдрах, оршиход суралцах” ойлголтод багтсан билээ.

Соёл хоорондын боловсролын асуудлыг энэ судалгааны хүрээнд бодлогын хүрээ, сургуулийн хөгжил, анги танхимд гэсэн 3 хүрээнд авч үзсэн.

Боловсролын бодлого ба сургалтын агуулгыг тодорхойлох байр сууринаас харахад сургалтын агуулга, арга зүйн хувьд сургалтын хөтөлбөр нь олон ургальч байдлыг хүндлэх, бүх төрлийн дээрэнгүй үзэл, хэвшмэл үзэмж, ялгаварлан гадуурхах үзлээс татгалзах зэрэг хүн төрөлхтний түгээмэл үнэт зүйлсэд суурилсан идэвхтэй байр суурьтай байхыг шаардаж байна.

Анги танхимд сургалтын идэвхтэй загваруудыг ашиглах, онол номлол дамжуулдаг аргаасаа бүрэн татгалзаж, хичээлийг амьд бүтээлч харилцаа болгох шаардлага тулгарна. Хүмүүнлэгийн ухааны мэдлэгийн зорилго нь эрэл хайгуул хийх, асуудлыг шийдвэрлэх, харилцан зөвшилцөл, ойлголцолд хүрэх, ингэснээрээ хүмүүст амьдралын утга учир, ертөнцийг үзэх чиг баримжаа олгох, өөрийн болон бусдын тухай мэдлэг бүтээхэд чиглэх болно.

Энэ асуудал багшийг хөгжүүлэх арга замыг дан ганц сургалт гэж үзэх өрөөсгөл хандлагаас татгалзаж, нийгэм түүхийн олон талт асуудлуудаар судалгаа хийх, илтгэл бичих, ном бүтээл туурвих, хурал семинар, дадлага зохион байгуулах, түршилт хийх зэрэг багшийг хөгжүүлэх өөр арга замуудыг сэдэж хэрэгжүүлэх шаардлага байна.

Ном зүй

- Дэлхийн иргэний боловсрол: Мониторингийн тайлан, Боловсролын хүрээлэн, УБ, 2017 он
- Ерөнхий боловсролын жендэрийн дүн шинжилгээ, Ц.Одгэрэл, С.Түмэндэлгэр, Н.Болдмаа, Т.Бүрэнжаргал, Д.Оюунцэцэг Б.Доржпагма, Жендэр судлал, Эрдэм шинжилгээний сэтгүүл, Тусгай дугаар, НХХЯ, ЖҮХ, УБ, 2016
- Монголын боловсролын хөгжлийн 25 жил: Түршлага, сургамж (1992-2017) Боловсролын шинжлэх ухааны академи, УБ, 2020 он
- Олон соёлын боловсрол: Харилцан ойлголцол” Бодлогын нөлөөлөлд ашиглах тойм мэдээлэл, “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвсэл, 2019 он
- Суурь боловсролын сургалтын хөтөлбөр, Түүх, нийгмийн ухаан, БСШУСЯ, УБ, 2019 он
- “Тогтвортой хөгжлийн зорилго 4-Боловсрол 2030”-ийг дэлгэрүүлж ойлгох нь, Гарын авлага, ЮНЕСКО, Боловсролын сектор, 2016
- Тува хэлний сургалтын хөтөлбөр, ХЭҮК, Канад сан, УБ, 2006 он
- “Хүний эрхийн боловсрол” илтгэл, Ч.Алтангэрэл, ХЭҮК, 2020 он
- Үндэстэн/угсаатны цөөнх хэмээх нэр томъёоны тайлбар, Доктор, Л.Алтанзаяа, МУБИС, 2018 он
- UNESCO Guidelines on Intercultural Education, Education Sector, 2006
- MTB MLE Resource Kit. Including the Excluded: Promoting Multilingual Education. Booklet for Programme Implementers. UNESCO Bangkok Office, 2016
- Global Citizenship Concepts in the Curricula of Four Countries, In-progress Reflection No16 on Current and Critical Issues in Curriculum, Learning and Assessment, UNESCO, IBE, APCEIU, 2017
- Tools for Planning and Monitoring Programmes of Multilingual Education in Asia, UNESCO Bangkok Office, 2020
- Global Education Monitoring Report 2020, Inclusion and Education: All Means All. UNESCO GEMR, 2020

“БҮХ НИЙТ БОЛОВСРОЛЫН ТӨЛӨӨ!” ИРГЭНИЙ НИЙГМИЙН ҮНДЭСНИЙ ЭВСЛИЙН ТУНХАГ

Боловсрол нь хүн бүрийн өдөр тутмын амьдралд, насан турш нөлөөлөх үндсэн эрх, хүний хөгжлийн түлхүүр бөгөөд иргэн бүрт чанартай боловсрол олгох нь төрийн хүлээх гол үүрэг хариуцлага гэдэгт итгэн;

Өнөөгийн тогтолцоонд боловсролыг явцуу тодорхойлдог, хүн бүрийн ялгаатай байдлыг харгалздаггүй, ялгаварлан гадуурхдаг, хангалттай санхүүжилт олгодоггүй зэргээс шалтгаалан бодлого төлөвлөх, хэрэгжүүлэх үйл явцад цогц хандлага дутагдаж; боловсролын тогтолцооны үр өгөөж нь хувь хүний хүсэл тэмүүлэл, нийгмийн эрэлт хэрэгцээнээс асар зөрүүтэй байсаар ирсний үлмаас үнэ цэнэтэй амьдарч, амьдралын чанараа дээшлүүлэх боломж олгохгүй байгаад сэтгэл зовнин;

Энэ нь эрх мэдлийн шударга бус бүтцийг бий болгож, тэгш бус байдлыг хадгалж үлдэх арга зам болж байгааг эсэргүүцэн;

Боловсролын чанар, хүртээмж, хариуцлагатай байдлын төлөө хүчээ нэгтгэн ажиллаж, энэ үйл явцад хувь хүн, иргэний нийгмийн байгууллага, бүлгүүдийг өргөнөөр татан оролцуулж, өргөн суурьтай, зохион байгуулалттай, хүчтэй хөдөлгөөн бий болгохыг чухалчлан;

Энэ үйл явцад нийгмийн бүх бүлэг, ялангуяа эрх мэдлийн цөөнхийн оролцоог хангахыг онцлон;

Иргэд, бүлгүүдийн мэдлэг, чадварыг хөгжүүлж, тулгарсан асуудлаа гаргаж ирэх, шийдлийг шаардах, хариуцлага тооцох чадавхтай болоход нь дэмжлэг үзүүлэхийг эрмэлзэн;

Боловсролын тогтолцоог хүний мэдэх, бүтээх, хүний ёсоор хамтран амьдарч, нэр төртэйгээр оршиход суралцахуйц, хувь хүний потенциал, чадвар, чадавхыг нээж, эерэг зан үйл, хандлагыг төлөвшүүлэхэд чиглэгдсэн, хүмүүнлэг, ардчилсан, хүн бүрийн эрхийг хангасан, тэгш хүртээмжтэй болгон өөрчлөхийг эрхэмлэн;

Хүүхэд, эцэг эх, багш, орон нутгийн бүлгүүд болон үндэсний, хэлний, соёлын, бэлгийн цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, орлого багатай иргэд зэрэг дуу хоолойгоо хүргэж, шийдвэр гаргахад оролцож чадахгүй байгаа бүлгүүдийг эрх мэдэлжүүлэх зорилгоор боловсролын тогтолцоо, бодлогод хяналт шинжилгээ, үнэлгээ хийх чадавхыг бүрдүүлэх, нөлөөлөх үр чадвараа дээшлүүлэх шаардлагыг ухамсарлан;

Хүний эрх, жендэрийн тэгш эрх, үл ялгаварлан гадуурхах, хүчирхийллээс ангид, хүлээцтэй байх, нээлттэй, ил тод, хариуцлагатай байх зарчмыг баримтлан;

Монгол улсад боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах, төсвийг хянах, хариуцлага шаардах, бодлогод нөлөөлөх үндэсний кампанит ажил зохион байгуулах зорилгоор эвсэн нэгдсэнээ тунхаглаж байна.

2010 оны 9 сарын 3

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

UIH.MN
СУДАЛГААНЫ САН



UIH.MN
СУДАЛГААНЫ САН